

АРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧИЙН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН

АЙМГИЙН ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧИЙН 2021 ОНЫ САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАНД ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

АУДИТЫН КОД:
АРА-2022/247/НА-СТА-ТЕЗ



ЦЭЦЭРЛЭГ ХОТ
2022 ОН

Архангай аймаг дахь Төрийн аудитын газрын дарга
бөгөөд Тэргүүлэх аудитор Т.Байгалмаа

Утас: 7033-3141 Цахим хаяг: baigalmaat@audit.gov.mn

Аудитын менежер Д.Нэргүйбаатар

Утас: 7033-2860 Цахим хаяг: nerguibaatard@audit.gov.mn

Ахлах аудитор Н.Алтантуяа

Утас: 9933-8611 Цахим хаяг: altantuyan@audit.gov.mn

Аудитор Л.Соёлмөнх

Утас: 9905-1581 Цахим хаяг: soyolmunkhl@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу. Цахим хуудас: www.audit.mn

Агуулга

Товчилсон үгийн жагсаалт	2
1.Аудитын гэрчилгээ.....	3
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл.....	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан.....	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан.....	5
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	6
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	7
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	8
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	9
3. Аудитын тайлан.....	10
3.1 Ерөнхий зүйл	10
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	10
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	11
3.4 Материаллаг байдал.....	11
3.5 санхүүгийн нэгтгэсэн тайлангийн үзүүлэлт	12
3.5.1 Мөнгөн хөрөнгө.....	12
3.5.2 Авлага	15
3.5.3 Урьдчилж төлсөн зардал.....	18
3.5.4 Бараа материал.....	18
3.5.5 Нөөцийн бараа	19
3.5.6 Бусад эргэлтийн хөрөнгө.....	20
3.5.7 Үндсэн хөрөнгө	20
3.5.8 Өр төлбөр	22
3.5.9 Засгийн газрын хувь оролцоо	24
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	25
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг.....	26
3.8 Аудитын гол асуудал.....	27
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	29
3.9.1 шилэн дансны хуулийн хэрэгжилт	29
3.9.2 Бусад хууль тогтоомжийн хэрэгжилт	30
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга	31
3.11 Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн	32
3.11.1 Төсвийн ерөнхийлөн захирагчийн аудитын илрүүлэлт	33
3.11.2 Аймгийн ТЕЗ-ийн харьяа байгууллагуудад хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүнгийн талаар.....	35
3.12 ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ БУЮУ АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДАЛ	37
4. АУДИТЫН ЗӨВЛӨМЖ.....	38
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл.....	39
6.Аймгийн ТЕЗ-аас ирүүлсэн асуудлын бүртгэлийн хариу.....	40
7. Аудитын тайлан баталгаажуулсан тушаал	41
8. Хүргүүлсэн албан шаардлага	43

Товчилсон үгийн жагсаалт

ААН	Аж ахуйн нэгж
АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
ГХБХБГ	Газрын харилцаа барилга хот байгуулалтын газар
ЕБС	Ерөнхий боловсролын сургууль
ЗГ	Засгийн газар
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
НББ	Нягтлан бодох бүртгэл
НБББББ	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
НДХ	Нийгмийн даатгалын хэлтэс
НӨАТ	Нэмэгдсэн өртгийн албан татвар
ОНӨААТҮГ	Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар
ОНӨГ	Орон нутгийн өмчийн газар
ОНӨҮГ	Орон нутгийн өмчит үйлдвэрийн газар
ОНТЕЗ	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагч
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
СТСХ	Санхүү төрийн сангийн хэлтэс
СХС	Сум хөгжүүлэх сан
ТБОНӨ	Төрийн болон орон нутгийн өмч
ТЕЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч
ТӨҮГ	Төрийн өмчит үйлдвэрийн газар
ТТЗ	Төсвийн төвлөрүүлэн захирагч
ТШЗ	Төсвийн шууд захирагч
ҮАГ	Үндэсний аудитын газар
ЦСҮТ	Цөм сүргийн үржлийн төв
ЭМТ	Эрүүл мэндийн төв
ЭМДС	Эрүүл мэндийн даатгалын сан
ХСУХАТАҮЗЗ	Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалт үйлчилгээг зохицуулах зөвлөл

1. Аудитын гэрчилгээ



АРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

65130 Цэцэрлэг, Архангай аймаг

Утас/Факс: 976-70333141

И-мэйл: arkhangai@audit.gov.mn

2022.04.19 № 180

танай _____ -ны № _____ -т

АРХАНГАЙ АЙМГИЙН ЗАСАГ
ДАРГА М.БАТЖАРГАЛ ТАНАА

Аудитын санал дүгнэлт

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.4-д заасны дагуу Архангай аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Архангай аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторовн баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгадагч байгууллагаас хараат бус, аудиторовн ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Т.БАЙГАЛМАА

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ мянган төгрөгөөр /

Код:	Тайлангийн үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	26,602,284.8	35,971,024.3
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	11,460,798.9	19,122,445.3
33	АВЛАГА	7,681,234.1	7,713,517.8
34	УРЬДЧИЛГАА	0.0	4,589.1
35	БАРАА МАТЕРИАЛ	6,997,875.9	8,407,014.1
36	НӨӨЦИЙН БАРАА	80,422.6	475,945.7
360	БУСАД ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГӨ	381,953.3	247,512.2
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	194,475,155.7	217,162,607.6
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	194,475,155.7	217,162,607.6
39200	Биет хөрөнгө	186,276,159.9	208,524,599.8
39300	Биет бус хөрөнгө	8,007,038.7	8,460,108.5
39400	Бусад хөрөнгө /ТӨҮГ/	191,957.1	177,899.3
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	221,077,440.4	253,133,631.9
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	12,407,862.6	12,546,741.4
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	1,236,906.1	1,331,244.2
41200	Богино хугацаат зээлийн өглөг	5,100.0	5,100.0
41300	Өглөг	1,191,177.4	1,195,863.0
41400	Урьдчилж орсон орлого	40,628.7	130,281.1
42	УРТ ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	11,170,956.5	11,215,497.3
42200	Урт хугацаат зээл	11,170,956.5	11,215,497.3
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	208,669,577.8	240,586,890.5
51	Засгийн газрын хувь оролцоо	208,669,577.8	240,586,890.5
51100	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	57,480,817.2	58,477,451.5
51101	Өмч /төрийн/ /ТӨҮГ/	4,704,604.7	4,651,935.9
51106	Эздийн өмчийн бусад хэсэг /ТӨҮГ/	3,414,850.9	3,414,850.9
51200	Хуримтлагдсан үр дүн	96,927,055.4	126,118,589.3
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	46,142,249.5	47,924,062.9
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	221,077,440.4	253,133,631.9

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ мянган төгрөгөөр /

Код:	Тайлангийн үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	146,586,588.4	156,709,847.2
11	ТАТВАРЫН ОРЛОГО	12,526,190.1	13,446,256.5
110	Орлогын албан татвар	7,867,649.3	8,287,141.5
1100	Хувь хүний орлогын албан татвар	8,426,313.3	8,847,188.5
1101	Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	-559,294.0	-560,047.0
1102	Орлогыг нь тухай бүр тодорхойлох боломжгүй ажил, үйлчилгээ хувиараа эрхлэгч	630.0	0.0
113	Хөрөнгийн албан татвар	739,535.2	2,507,093.8
118	Бусад татвар, төлбөр, хураамж	3,919,005.6	2,652,021.1
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	108,001,979.6	114,220,488.5
120	Нийтлэг татварын бус орлого	40,021,801.8	46,426,504.9
121	Хөрөнгийн орлого	63,724.3	31,315.3
122	Тусламжийн орлого	2,800.0	36,092.8

**Архангай аймгийн ТЭЗ-ийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд
хийсэн санхүүгийн аудитын тайлан**

123	Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	67,913,653.5	67,726,575.5
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	26,058,418.7	29,043,102.2
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	103,535,110.2	98,636,521.5
21	УРСГАЛ ЗАРДАЛ	103,535,110.2	97,879,925.4
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	99,399,465.0	93,240,002.6
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	46,855,087.0	50,301,057.6
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	6,122,700.6	6,725,437.1
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	5,731,485.9	6,192,451.4
2104	Хангамж, бараа материалын зардал	2,575,656.3	2,750,944.0
2105	Нормативт зардал	4,556,533.8	9,138,147.7
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	732,414.9	773,365.5
2107	Томилолт, зочны зардал	193,576.6	176,356.4
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	3,409,463.7	2,704,137.4
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	29,222,546.0	14,478,105.5
212	ТАТААС	87,885.0	88,661.8
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	4,047,760.2	4,551,261.0
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	0.0	756,596.1
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	43,051,478.2	58,073,325.8
IV	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН	0.0	254,706.8
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	39,818,309.5	30,602,996.2
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	3,233,168.7	27,725,036.4

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ мянган төгрөгөөр /

Код:	Тайлангийн үзүүлэлт	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн	Нийт цэвэр хөрөнгө/өмч
1	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	201,360,754.1	201,360,754.1
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	6,599,884.7	6,599,884.7
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	207,960,638.8	207,960,638.8
4	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	-3,883,387.4	-3,883,387.4
5	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	1,359,157.7	1,359,157.7
6	Тайлант үеийн үр дүн	3,233,168.7	3,233,168.7
7	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	208,669,577.8	208,669,577.8
8	2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	208,669,577.8	208,669,577.8
9	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	4,361,093.4	4,361,093.4
10	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	213,030,671.2	213,030,671.2
11	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	-105,303.7	-105,303.7
12	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	-63,513.4	-63,513.4
13	Тайлант үеийн үр дүн	27,725,036.4	27,725,036.4
14	2021 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	240,586,890.5	240,586,890.5

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/мянган төгрөгөөр /

Код:	Тайлангийн үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	113,053,539.5	121,176,594.7
11	ТАТВАРЫН ОРЛОГО	12,526,190.1	13,498,736.5
110	Орлогын албан татвар	7,867,649.3	8,287,141.5
1100	Хувь хүний орлогын албан татвар	8,426,313.3	8,847,188.5
1101	Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	-559,294.0	-560,047.0
1102	Орлогыг нь тухай бүр тодорхойлох боломжгүй ажил, үйлчилгээ хувиараа эрхлэгч	630.0	0.0
113	Хөрөнгийн албан татвар	739,535.2	2,507,093.8
118	Бусад татвар, төлбөр, хураамж	3,919,005.6	2,704,501.1
1180	Бусад нийтлэг төлбөр, хураамж	478,142.6	567,844.3
1181	Газрын төлбөр	613,175.7	554,214.8
1182	Байгалийн нөөц ашигласны төлбөр	2,827,687.3	1,582,442.0
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	74,468,930.8	79,940,122.3
120	Нийтлэг татварын бус орлого	6,491,553.0	12,163,626.9
121	Хөрөнгийн орлого	63,724.3	89,919.9
123	Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	67,913,653.5	67,686,575.5
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	26,058,418.7	27,737,736.0
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	78,742,344.7	84,594,230.7
21	УРСГАЛ ЗАРДАЛ	78,742,344.7	84,594,230.7
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	75,198,184.8	79,955,812.2
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	47,198,029.7	50,876,721.1
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	6,285,361.8	6,671,732.5
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	5,797,343.3	6,499,835.4
2104	Хангамж, бараа материалын зардал	2,168,393.5	2,196,625.7
2105	Нормативт зардал	4,191,835.8	4,412,703.6
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	777,306.5	896,156.7
2107	Томилолт, зочны зардал	194,091.4	176,413.4
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	3,476,822.0	3,501,801.9
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	5,109,001.0	4,723,821.9
212	ТАТААС	87,841.8	88,961.8
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	3,456,318.1	4,549,456.7
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	34,311,194.8	36,582,364.0
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	31,110,650.5	27,720,572.2
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	31,110,650.5	27,720,572.2
2200	Дотоод эх үүсвэрээр	31,110,650.5	27,720,572.2
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	-31,110,650.5	-27,720,572.2
VII	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН	-1,657,260.2	-1,200,145.5
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	1,653,740.0	1,191,645.0
25	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДАЛ	3,520.2	8,500.5
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	1,543,284.0	7,661,646.4
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	9,917,514.9	11,460,798.9
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	11,460,798.9	19,122,445.3

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ мянган төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	90,502,137.5	81,726,254.7
21	УРСГАЛ ЗАРДАЛ	77,557,026.1	74,620,582.7
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	75,836,255.3	73,003,211.4
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	48,803,239.1	48,481,728.1
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	6,523,373.8	6,415,965.9
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	6,197,253.7	6,098,655.2
2104	Хангамж, бараа материалын зардал	1,820,286.9	1,691,123.0
2105	Нормативт зардал	2,971,733.7	2,629,188.7
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,261,004.3	1,173,792.3
2107	Томилолт, зочны зардал	212,710.9	163,555.4
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,589,809.8	2,301,753.1
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	5,456,843.1	4,047,449.6
212	ТАТААС	108,961.8	88,961.8
2121	Төрийн өмчит байгууллагад олгох татаас	20,000.0	0.0
2122	Хувийн хэвшлийн байгууллагад олгох татаас	88,961.8	88,961.8
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,611,809.0	1,528,409.5
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	117,000.0	117,000.0
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,494,809.0	1,411,409.5
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	9,894,094.8	5,914,026.9
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	3,051,016.6	1,191,645.0
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	90,502,137.5	85,977,248.6
31	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	49,137,764.6	48,718,205.6
32	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	30,220,189.5	33,534,429.4
33	НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	748,362.6	524,537.8
35	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	10,395,820.8	3,200,075.7
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.0	1,377,089.9
5	Мөнгө, түүнтэй адилтгаа хөрөнгийн эхний үлдэгдэл	0.0	5,584,877.1

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/мянган төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	6,848,638.3
21	УРСГАЛ ЗАРДАЛ	6,600,516.1
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	5,624,772.6
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,557,190.5
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	76,954.2
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	30,087.7
2104	Хангамж, бараа материалын зардал	325,147.4
2105	Нормативт зардал	1,689,973.6
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	331,121.8
2107	Томилолт, зочны зардал	11,774.2
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	397,656.4
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1,204,866.8
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	975,743.5
2132	Бусад урсгал шилжүүлэг	738,767.5
2133	Олгосон, санхүүжилт шилжүүлэг	236,976.5
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	248,122.2
221	Дотоод эх үүсвэрээр	248,122.2
I	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	6,946,226.6
1311	Нэмэлт санхүүжлтийн орлого	6,946,226.6
III	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)	97,588.3
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	97,588.3

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Архангай аймгийн ТЕЗ-ийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч байгууллагаас, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд өр төлбөрийн данс, нягтлан бодох бүртгэл тайлагналтай холбоотой зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг Архангай аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Н.Алтантуяа, аудитор Л.Соёлмөнх нар гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Д.Нэргүйбаатар, дарга, тэргүүлэх аудитор Т.Байгалмаа нар тус тус хэрэгжүүллээ.

Архангай аймгийн ТЕЗ-ийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төрийн аудитын газарт 2022 оны 4 дүгээр сарын 01-ний өдрийн 01/571 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулинд “Аймаг нь хуулиар тусгайлан олгосон чиг үүргийн хүрээнд эдийн засаг, нийгмийн асуудлаар бие даан шийдвэр гаргах, сумдын үйл ажиллагааг зохицуулах, хууль тогтоомжийн биелэлтийг хангах, хяналтыг хэрэгжүүлэх нэгж мөн”, Аймгийн Засаг дарга нь “харьяалах нутаг дэвсгэртээ хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэр, харьяалах дээд шатны Засаг даргын шийдвэрийн гүйцэтгэлийг хангах, түүнчлэн тухайн Хурлын шийдвэрийг хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий төрийн төлөөлөгч мөн” гэж заажээ.

Аймгийн ТЕЗ-ийн зорилго, үйл ажиллагааг Аймгийн засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт “Алсын хараа-2050” урт хугацааны хөгжлийн бодлогод нийцүүлсэн “Монгол Улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”, “Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”, “Архангай аймгийг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”-ийг хэрэгжүүлэхэд чиглэсэн бодлогыг үндэслэн тодорхойлсон байна.

Энэхүү хөтөлбөрт Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилсан “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөн, Засгийн газраас дэвшүүлсэн “Цахим шилжилт”, “Ногоон байгууламж”, “Хог хаягдлын менежмент” бодлого, зорилтыг орон нутагт үр дүнтэй хэрэгжүүлэх үүрэг чиглэлийг баримталжээ.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрдөх хууль, тогтоомж, бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- ЗГ-ын 2021 оны 43 дугаар тогтоол “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай”
- ЗГ-ын 2021 оны 124 дүгээр тогтоол “Босго үнэ шинэчлэн батлах тухай”;
- Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр тушаалаар “Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар

Аймгийн ТЕЗ-ийн зүгээс хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэхэд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Аймгийн ТЕЗ-ийн мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Өмнөх оны ТЕЗ-ийн аудитаар аймгийн ТЕЗ-ийн харьяа байгууллагуудад мөрдөх Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигтэй болох талаар өгсөн зөвлөмжийн дагуу “Аймгийн ТЕЗ-ийн багцын харьяа төсөвт байгууллагуудад мөрдөх” НБББББ-ийг аймгийн Засаг даргын 2021 оны 12 дугаар сарын 14-ний өдрийн А/841 дугаар захирамжаар баталсан байна.

Тайлант онд аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт, аудитын алба нь эрсдэлийн үнэлгээнд суурилан төсвийн ерөнхийлөн захирагчийн харьяа 69 төсөвт байгууллагад аудит, хяналт шалгалт хийхээр төлөвлөсөн бөгөөд төлөвлөгөөний дагуу 69, төлөвлөгөөт бус 8 байгууллага нийт 77 байгууллагын үйл ажиллагаанд үнэлэлт дүгнэлт өгч, цаашид анхаарах асуудлаар зөвлөмж бэлтгэн харилцагч байгууллагын төсөв захирагч нарт хүргүүлж, биелэлтийг тооцон ажилласан байна. Аудит, хяналт шалгалтаар 1,548.1 сая төгрөгийн зөрчил илрүүлж, улсын байцаагчийн 72 актаар 227.9 сая төгрөгийн нөхөн төлбөр тогтоож, тайлант хугацаанд 185.7 сая төгрөгийн нөхөн төлбөрийг барагдуулан, улсын байцаагчийн 36 албан шаардлагаар 1,320.1 сая төгрөгийн зөрчлийн арилгуулах хугацаатай үүрэг өгч, биелэлтийг 83 хувьтай гэж үнэлсэн байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудиторос шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 САНХҮҮГИЙН ТАЙЛАГНАЛЫН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Архангай аймгийн ТЕЗ-ийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлсөн, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

3.4 МАТЕРИАЛЛАГ БАЙДАЛ

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2021 оны санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлангийн зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлангийн зардал 105,115.1 сая төгрөгөөс 1 хувиар буюу 1,051.1 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувиар буюу 788.3 сая төгрөгөөр тогтоосон.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшнийг аудитын хугацаанд санхүүгийн тайланд залруулга хийсэнтэй холбоотой 2021 оны залруулсан санхүүгийн үр дүнгийн нэгтгэсэн тайлангийн нийт зардал 98,636.5 сая төгрөгийн 1.0 хувь буюу 986.3 сая төгрөгөөр шинэчлэн тогтоосон болно.

3.5 САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАНГИЙН ҮЗҮҮЛЭЛТ

3.5.1 Мөнгөн хөрөнгө

Мөнгөн хөрөнгийн оны эхний үлдэгдэл **11,460.8** сая төгрөг, эцсийн үлдэгдэл **19,122.4** сая төгрөг болж, **7,661.6** сая төгрөгөөр өссөн байна.

Мөнгөн хөрөнгийн үлдэгдлийн 97.6 хувь буюу 18,658.8 сая төгрөг нь төрийн сангийн харилцах дансанд, 2.4 хувь буюу 463.6 сая төгрөг нь арилжааны банкинд байна.

Хүснэгт №1. Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл

/сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+) Бууралт(-)	Дүнд эзлэх хувь
Кассад байгаа бэлэн мөнгө:	1.0	-	(1.0)	-
Банкинд байгаа бэлэн мөнгө:	11,459.8	19,122.4	7,662.6	100.0
Төрийн сангийн харилцах	10,967.0	18,658.8	7,691.8	97.6
Арилжааны банкны харилцах	492.8	463.6	(29.2)	2.4
Нийт мөнгөн хөрөнгийн дүн	11,460.8	19,122.4	7,661.6	100.00
Үүнээс байгууллагын төрлөөр:				
Төсвийн байгууллага	1,335.0	5,639.2	4,304.2	29.5
Төрийн сан	6,717.7	6,793.5	75.8	35.5
Төсөл сан	2,914.3	6,242.0	3,327.7	32.6
ОНӨҮГазар	493.8	447.7	(46.1)	2.4
Нийт мөнгөн хөрөнгийн дүн	11,460.8	19,122.4	7,661.6	100.00

Эх сурвалж: Аймгийн ТЭЗ-ийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Нийт мөнгөн хөрөнгийн 29.5 хувь буюу 5,639.2 сая төгрөгийг төсөвт байгууллагын, 35.5 хувь 6,793.5 сая төгрөгийг төрийн сангийн, 32.7 хувь буюу 6,242.0 сая төгрөгийг төсөл сангийн, 2.3 хувь буюу 447.7 сая төгрөгийг орон нутгийн өмчит үйлдвэрийн газруудын үлдэгдэл эзэлж байна.

Хүснэгт №2. Мөнгөн хөрөнгө байршиж буй хэлбэр

/сая төгрөг/

Байгууллагын төрлөөр:	Мөнгөн хөрөнгө байршиж буй хэлбэр		Нийт мөнгөн хөрөнгийн эцсийн үлдэгдэл
	Банкинд байгаа бэлэн мөнгө :		
	Төрийн сан	Арилжааны банк	
Төсвийн байгууллага	5,623.3	15.9	5,639.2
Төрийн сан	6,793.5		6,793.5
Төсөл сан	6,242.0		6,242.0
ОНӨҮГазар		447.7	447.7
Нийт мөнгөн хөрөнгийн дүн	18,658.8	463.6	19,122.4

Эх сурвалж: Аймгийн ТЭЗ-ийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Төсвийн байгууллагын 15.9 сая төгрөгийн мөнгөн хөрөнгийн үлдэгдэл нь Эрдэнэбулган сумын 3 өрхийн ЭМТ-ийн, арилжааны банкинд 4 орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын үлдэгдэл байна.

Төрийн сангийн харилцах дансанд байршиж буй мөнгөн хөрөнгө

Төрийн сангийн мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл 10,967.0 сая төгрөг, эцсийн үлдэгдэл 18,658.8 сая төгрөг болж, 7,691.8 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №3. Төрийн сангийн мөнгөн хөрөнгийн үлдэгдэл

/сая төгрөг/

№	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
1	Төсөвт байгууллагын мөнгөн хөрөнгийн үлдэгдэл	1,335.0	5,623.3	4,288.3
1.1	Сумдын ОНХС /19 сум/	671.9	2,271.2	1,599.3
1.2	Аймгийн ОНХС	37.8	896.8	859.0
1.3	Сум хөгжүүлэх сан/19 сум/	625.3	2,259.1	1,633.8
1.4	Сумдын ЭМТ	-	196.2	196.2
2	Төрийн сангийн мөнгөн хөрөнгийн үлдэгдэл	6,717.7	6,793.5	75.8
2.1	Төрийн сангийн үлдэгдэл -ОНЕО /19 сум/	4,400.7	3,665.3	(735.4)
2.2	Төрийн сангийн үлдэгдэл -ОНЕО /аймаг/	2,317.0	3,128.2	811.2
3	Төсөл сангийн мөнгөн хөрөнгийн үлдэгдэл	2,914.3	6,242.0	3,327.7
3.1	Хөрөнгө оруулалтын барьцаа хөрөнгийн данс	2,569.4	5,830.3	3,260.9
3.2	Нэмэлт санхүүжилтийн татан төвлөрүүлэлтийн данс	162.3	232.5	70.2
3.3	Техник хяналтын зардлын данс	140.5	120.0	(20.5)
3.4	Аймгийн мал эрсдлээс хамгаалах сан	42.1	59.2	17.1
	Төрийн сангийн нийт мөнгөн хөрөнгийн дүн /1+2+3/	10,967.0	18,658.8	7,691.8

Эх сурвалж: Аймгийн ТЭЗ-ийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Төсвийн байгууллага ангилалд аймаг, сумдын ОНХС-ийн 3,168.0 сая төгрөг, сум хөгжүүлэх сангийн 2,259.1 сая төгрөгийн үлдэгдэл тайлагнагдсан байна. Харин төрийн сан ангилалд аймаг болон 19 сумын орон нутгийн ерөнхий орлогын дансны 6,793.5 сая төгрөгийн үлдэгдэл, төсөл сан ангилалд аймгийн хөрөнгө оруулалтын барьцаа хөрөнгийн дансны 5,830.3 сая төгрөг, нэмэлт санхүүжилтийн татан төвлөрүүлэлтийн 232.5 сая төгрөг, техник хяналтын зардлын 120.0 сая төгрөг, мал хамгаалах сангийн 59.2 сая төгрөгийн мөнгөн хөрөнгийн үлдэгдэл байна.

Аймгийн төрийн сангийн ерөнхий орлогын дансанд 3,128.2 сая төгрөгийн үлдэгдэл байгаа ба үүнд аймгийн засаг дарга дансны 813.9 сая төгрөг орон нутгийн төсөвт байгууллагуудын хэмнэлтээр төвлөрүүлсэн 635.2 сая төгрөг, бусад нь орон нутгийн давсан орлогын үлдэгдэл байна.

Хөрөнгө оруулалтын барьцаа хөрөнгийн дансны эхний үлдэгдэл 2,569.4 сая төгрөг, тайлант онд улс, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээний 2021 оны зарцуулагдаагүй үлдэгдэл 5,290.4 сая төгрөгийг байршуулснаас 2,029.5 сая төгрөгийн зарцуулалт гарч, оны эцэст 5,830.3 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Нэмэлт санхүүжилтийн татан төвлөрүүлэлтийн дансны эхний үлдэгдэл 162.3 сая төгрөг, тайлант онд төсөв байгууллагуудын нэмэлт санхүүжилтийн зарцуулагдаагүй үлдэгдэл 204.9 сая төгрөгийг төвлөрүүлж, 134.7 сая төгрөгийн зарцуулалт гарч, оны эцэст 232.5 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Техник хяналтын зардал дансны эхний үлдэгдэл 140.5 сая төгрөг, тайлант онд Зам Тээврийн Яамны хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээний техник хяналтын зардлын 134.2 сая төгрөгийг байршуулснаас 154.7 сая төгрөгийг зарцуулж, 120.0 сая үлдэгдэлтэй байна.

Мал хамгаалах сангийн эхний үлдэгдэл 42.1 сая төгрөг, тайлант онд 27.7 сая төгрөгийн орлого төвлөрүүлэн, 10.6 сая төгрөгийн зарцуулалт гарч, оны эцэст 59.2 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Арилжааны банкны харилцах дансанд байршиж буй мөнгөн хөрөнгө

Арилжааны банкинд байршиж байгаа мөнгөн хөрөнгийн үлдэгдлийн 96.6 хувь буюу 447.7 сая төгрөг нь ОНӨААТҮГ-уудын, 3.4 хувь буюу 15.9 сая төгрөг нь өрхийн ЭМТ-үүдийн үлдэгдэл байна.

Хүснэгт № 4 Арилжааны банкны мөнгөн хөрөнгийн үлдэгдэл

/сая төгрөг/

Байгууллагын нэр	Үлдэгдэл		Нийт үлдэгдэл	Дансны тоо
	Харилцах данс	Хугацаатай хадгаламж		
Архангайд үйлдвэрлэв ОНӨААТҮГ	19.2		19.2	3
Ундарга ОНӨААТҮГ	126.8	300.0	426.8	8
Цөм сүрэг үржлийн төв ОНӨААТҮГ	0.4		0.4	1
Эрдэнэмандал шилмэл сүргийн үржил ОНӨААТҮГ	1.3		1.3	1
Ар- Мөнгөнчагнуур ЗГБХ нөхөрлөл / Өрхийн ЭМТ/	12.1		12.1	1
Ар Манал ЗГБХ нөхөрлөл / Өрхийн ЭМТ/	0.4		0.4	1
Ар Мөнхжин ЗГБХ нөхөрлөл / Өрхийн ЭМТ/	3.4		3.4	1
НИЙТ ДҮН	163.6	300.0	463.6	16

Эх сурвалж: Аймгийн ТЭЗ-ийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Аймгийн ТЭЗ-ийн тайлангаарх мөнгөн хөрөнгийн өсөлтөд ковид цар тахлын хөл хориотой холбоотойгоор аймаг, сумдын ОНХС, СХС-ийн хөрөнгийн зарцуулалт буурсан, Засгийн Газрын шийдвэрээр хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээний үлдэгдэл санхүүжилтийг хөрөнгө оруулалтын барьцаа хөрөнгийн дансанд байршуулж үлдэгдлээр тайлагнасан зэрэг нь голлон нөлөөлжээ.

Аудитын илрүүлэлт

2021 оны санхүүгийн тайлангийн аудитаар мөнгөн хөрөнгийн орлого, зарлагатай холбоотой дараах зөрчлүүд илэрсэн. Үүнд:

- Батцэнгэл сумын ЕБС -1.2 сая, Булган сумын ЕБС-1.7 сая, Тариат сумын ЕБС-5.8 сая, Ихтамир сумын ЕБС -2.9 сая, Өгийнуур сумын ЕБС -2.0 сая, Цэнхэр сумын ИТХ -3.1 сая, Цөм сүрэг үржлийн төв- 2.0 сая нийт 18.7 сая төгрөгийн цахим төлбөрийн баримтаар баталгаажаагүй анхан шатны баримтаар гүйлгээ хийсэн зөрчил илэрсэнд аудитаас зөрчлийг давтан гаргасан нөхцөл байдлыг харгалзан НББ-ийн тухай хуулийг мөрдөж ажиллах албан шаардлага, зөвлөмжийг хүргүүлэн ажиллалаа.
- Хотонт сумын хүүхдийн цэцэрлэг – 0.4 сая, Цэцэрлэг сумын ЭМТ -1.4 сая, Номын сан -0.4 сая, Музей -0.5 сая төгрөгийн нийт 2.7 сая төгрөгийн тээвэр шатахууны зардлын анхан шатны баримтын бүрдэл дутуу буюу жолоочийн тооцооны хуудасгүй зөрчил илэрсэнд аудитаас зөрчлийг арилгуулах албан шаардлага, зөвлөмжийг хүргүүлсэн байна.
- Музей -0.7 сая, ХДТеатр -1.8 сая, ОНӨГ- 0.2 сая төгрөгийн томилолтын зардлын анхан шатны баримтын бүрдэл дутуу нийт 2.7 сая төгрөгийн зөрчилд албан шаардлага, зөвлөмжийг хүргүүлсэн.
- Хангай сумын хүүхдийн цэцэрлэг анхан шатны баримтгүйгээр 0.1 сая төгрөгийг томилолтонд зарцуулсанд төлбөрийн акт тогтоосон.

- Цөм сүрэг үржлийн төв ОНӨААТҮГ нь сар бүр цалингийн тооцооны дансыг хөтлөөгүй, анхан шатны баримтын бүрдэлгүй 9.2 сая төгрөгийн зөрчил илэрсэнд зөрчлийг арилгуулах албан шаардлага хүргүүлээд байна.
- Төвшрүүлэх сумын ЗДТГ түлш халаалтын зардлын анхан шатны баримт бүрдүүлэлт дутуу, хангалтгүй зөрчил илэрсэнд аудитаас зөрчлийг арилгуулах зөвлөмж хүргүүлээ.

3.5.2 Авлага

Авлагын дансны оны эхний үлдэгдэл **7,681.2** сая төгрөг, эцсийн үлдэгдэл **7,713.5** сая төгрөг болж, **32.3** сая төгрөгөөр өссөн байна.

Нийт авлагын 79.7 хувь нь хувь хүнээс авах авлага, 17.4 хувь нь төлбөртэй үйлчилгээний авлага, 2.9 хувь нь байгууллагаас авах авлага болон бусад авлага тус тус эзэлж байна.

Хүснэгт №5. Авлагын үлдэгдэл

/сая төгрөг/

Авлагын ангилал	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+) Бууралт(-)	Дүнд эзлэх хувь
Ажилчидтай холбоотой авлага	12.4	28.1	15.7	0.4
Төлбөртэй үйлчилгээний авлага	4.2	1,338.0	1,333.8	17.3
Байгууллагаас авах авлага	52.6	161.9	109.3	2.1
Дансны авлага/ ТӨҮГ/	35.5	35.8	0.3	0.5
Татвар НДШ -ийн авлага /ТӨҮГ/	1.4	1.1	(0.3)	0.0
Хувь хүнээс авах авлага	7,575.1	6,148.6	(1,426.5)	79.7
Нийт дүн	7,681.2	7,713.5	32.3	100.0
Үүнээс байгууллагын төрлөөр харуулбал:				
Төсвийн байгууллага	7,548.3	7,540.5	(7.8)	97.8
Төрийн сан	46.4	46.4	-	0.6
Төсөл сан	44.8	10.2	(34.6)	0.1
ОНӨҮГазар	41.7	116.4	74.7	1.5
Нийт дүн	7,681.2	7,713.5	32.3	100.0

Эх сурвалж: Аймгийн ТЕЗ-ийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Нийт авлагын 97.8 хувь буюу 7,540.5 сая төгрөг нь төсөвт байгууллагын, 0.6 хувь буюу 46.4 сая төгрөг нь төрийн сангийн, 0.1 хувь буюу 10.2 сая төгрөг нь төсөл сангийн, 1.5 хувь буюу 116.4 сая төгрөг нь ОНӨҮГ-ын авлага байна.

Төсөвт байгууллагын авлага

Төсөвт байгууллагын авлага ангилалд тайлагнагдсан нийт 7,540.5 сая төгрөгийн авлагын 79.1 хувь буюу 5,964.9 сая төгрөг нь сум хөгжүүлэх сангийн, 17.7 хувь буюу 1,332.6 сая төгрөг нь сумдын ЭМТ-ийн ЭМДС-аас авах авлага, 0.4 хувь буюу 30.0 сая төгрөг нь аймгийн засаг даргын хөтөлбөр арга хэмжээний зардлаас олгосон зээл, 2.8 хувь буюу 213.0 сая төгрөг нь аймаг, сумдын зарим төсөвт байгууллагуудын авлага байна.

**Архангай аймгийн ТЭЗ-ийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд
хийсэн санхүүгийн аудитын тайлан**

Хүснэгт № 6 СХС-ийн авлагын үлдэгдэл				/сая төгрөг/
№	Сумдын нэр	Авлагын эхний үлдэгдэл	Авлагын эцсийн үлдэгдэл	Зөрүү
1	Булган	266.9	254.6	(12.3)
2	Батцэнгэл	369.8	230.9	(138.9)
3	Жаргалант	390.7	255.9	(134.7)
4	Ихтамир	476.9	404.2	(72.7)
5	Өгийнуур	282.8	288.7	5.9
6	Өлзийт	322.4	288.7	(33.8)
7	Өндөр-Улаан	410.4	478.9	68.5
8	Тариат	470.0	309.4	(160.6)
9	Төвшрүүлэх	348.5	139.1	(209.3)
10	Хангай	261.6	156.6	(105.0)
11	Хотонт	379.2	345.9	(33.2)
12	Хайрхан	346.9	221.0	(125.9)
13	Хашаат	306.6	168.9	(137.7)
14	Цахир	262.3	142.8	(119.5)
15	Цэнхэр	332.1	305.5	(26.6)
16	Цэцэрлэг	340.2	228.3	(111.8)
17	Чулуут	325.8	325.8	0.1
18	Эрдэнэбулган	1,182.5	1,009.4	(173.0)
19	Эрдэнэмандал	316.4	410.1	93.7
	ДҮН	7,391.9	5,964.9	(1,426.9)

Эх сурвалж: Аймгийн ТЭЗ-ийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Сум хөгжүүлэх сангийн зээлийн авлага 5,964.9 сая төгрөг болж өмнөх оноос 1,426.9 сая төгрөгөөр буурсан байна. Тус зээлийн авлагыг хугацаагаар нь ангилж авч үзвэл:

Нийт авлагын 59.4 хувь буюу 3,543.0 сая төгрөг нь хугацаандаа төлөгдөж байгаа хэвийн зээл, 19.6 хувь буюу 1,165.9 сая төгрөг нь зээл төлөх хуваариас 90 хүртэл хоног хэтэрсэн зээл, 21.0 хувь буюу 1,256.0 сая төгрөг нь 90-ээс дээш хоногоор хэтэрсэн зээл байна. Өөрөөр хэлбэл нийт авлагын 40.5 хувь нь хугацаа хэтэрсэн зээлийн авлага байгаа бөгөөд тус зээлүүдийг төлүүлэх талаар сумын засаг дарга нарын зүгээс хугацаатай мэдэгдэл хүргүүлэн, хууль хяналтын байгууллагаар шийдвэрлүүлэн ажиллаж байгаа хэдий ч 5-10 жилийн насжилттай авлагын дүн буурахгүй байна.

Аудитаар 19 сумын сум хөгжүүлэх сангийн зээлийн авлагын үлдэгдлийг насжилтаар нь судлан авч үзэхэд 5-аас дээш жил насжилттай буюу 2011-2016 онуудад үүссэн 1,691.9 сая төгрөгийн авлагын үлдэгдэлтэй байгаа бөгөөд насжилт нэмэгдэхийн хэрээр авлага найдваргүй болох, сангийн хөрөнгийн эх үүсвэр дутагдах эрсдэл бий болсон тул аймгийн засаг даргад зээлийг барагдуулахад тодорхой арга хэмжээ, албан даалгавар боловсруулан сумдын засаг дарга нарт үүрэг чиглэл хүргүүлэн биелэлтийг тооцож, ажиллах албан шаардлагыг хүргүүлэхээр шийдвэрлэлээ.

Сумын ТЭЗ-ийн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар СХС-ийн хугацаа хэтэрсэн зээлүүдийг барагдуулах талаар дорвитой арга хэмжээ авч, эргэн төлөлтийг эрчимжүүлэн ажиллах албан шаардлагыг бүх сумдын удирдлагуудад хүргүүлээд байна.

Төрийн сангийн авлага

Төрийн сангийн авлага 46.3 сая төгрөгийн үлдэгдэлтэйгээс 39.8 сая төгрөг нь 2001 онд үүссэн 20 жилийн насжилттай өвс тэжээлийн авлага, 6.5 сая төгрөг нь Атрын 3-р аяны хүрээнд иргэдэд эргэн төлөгдөх нөхцөлөөр олгосон зээлийн авлага бөгөөд ямар байгууллага, хувь хүнээс авах нь тодорхойгүй эзэн холбогдогчгүй байна. Эдгээр авлагыг

барагдуулах талаар өмнөх жилүүдийн аудитаар зөвлөмж хүргүүлэн, ҮАГ-т санал уламжилж байсан боловч шийдэгдээгүй, 2021 онд уг авлага тайланд тусгагдсан хэвээр байна.

Төсөл сангийн авлага

Төсөл сан ангилалд тайлагнагдсан нийт 10.2 сая төгрөгийн авлага нь аймгийн мал хамгаалах сангийн авлага байгаа бөгөөд өмнөх жилийн аудитаар авлагыг барагдуулах арга хэмжээг авч ажиллах албан шаардлага хүргүүлсний дагуу тус авлагыг барагдуулахаар шүүхэд шилжүүлсэн ба шүүхийн шийдвэр эцэслэн гараагүй байна.

ОНӨААТҮГ-ын авлага

ОНӨААТҮГ-ууд нь нийт 116.4 сая төгрөгийн авлагатайгаас 91.6 хувь буюу 106.6 сая төгрөг нь Ар-ус Ундарга ОНӨААТҮГ-ын, 5.9 хувь буюу 6.9 сая төгрөг нь Архангайд үйлдвэрлэв ОНӨААТҮГ-ын, 2.5 хувь буюу 2.9 сая төгрөг нь Чулуут ахуйн үйлчилгээний төв ОНӨҮГ-ын авлага байна.

Ар-ус Ундарга ХХК ОНӨҮГ-ын 106.6 сая төгрөгийн авлагыг тодруулбал: Байгууллагаас авах авлага 4.7 сая төгрөг, хувь хүнээс авах 101.9 сая төгрөг нь төрөөс хариуцаж төлөх усны төлбөрийн хөнгөлөлт бүрэн орж ирээгүйтэй холбоотой үүссэн авлага байна.

Аймгийн ТЭЗ-ийн тайлангаарх авлагын өсөлтөнд ковид цар тахлын үеийн эмнэлгийн цогц тусламж үйлчлээний санхүүжилттэй холбоотойгоор ЭМДС-аас авах ЭМТ-үүдийн төлбөртэй үйлчилгээний авлагын үлдэгдэл өссөн, СХС-ийн журам өөрчлөгдөн Хоршоо хөгжүүлэх сан болгох шийдвэртэй холбоотойгоор СХС-аас олгох зээл буурч, зээл төлөгдөж хувь хүнээс авах авлагын үлдэгдэл буурсан нь голлон нөлөөлжээ.

Аудитын илрүүлэлт

2021 оны санхүүгийн тайлангийн аудитаар авлагын данстай холбоотой дараах зөрчлүүд илэрсэн байна.

- Чулуут сумын хүүхдийн цэцэрлэг нь 3.0 сая төгрөгийн төсвийн үлдэгдлийг НДХ-т илүү тооцоо үүсгэн шилжүүлж авлага үүсгээсэнд төлбөрийн акт тогтоосон.
- ХДТеатр 0.4 сая төгрөгийн татварын илүү төлөлт үүсгэсэн, Өлзийт сумын ЗДТГ 21 жилийн насжиттай 0.5 сая, Хайрхан сумын ЭМТ 18 жилийн насжиттай 0.1 сая, Хайрхан сумын ЗДТГ хувь хүнтэй холбоотой 1.5 сая, Чулуут сумын ЗДТГ хувь хүнтэй холбоотой 19.1 сая, ОНӨГ түрээсийн орлоготой холбоотой 1.2 сая, Эрдэнэмандал сумын ЭМТ нь ЭМДС-ийн дутуу санхүүжилттэй холбоотой 105.1 сая төгрөгийн тус тус авлагатай ажилласанд зөрчлийг арилгуулах албан шаардлага хүргүүлсэн байна.
- Хайрхан сумын ЕБС НДШ-ийг буруу тооцсноос 6.0 сая төгрөгийн илүү төлөлт хийсэн, Цахир сумын ЗДТГ нь цөм сүргийн нийт 319 толгой бог мал борлуулж, 42.3 сая төгрөгийн авлага үүсгэсэн зэрэг зөрчилд зөрчлийг арилгуулах албан шаардлага хүргүүлээ.
- ОНӨГ нь дуудлага худалдааны орлоготой холбоотой 0.4 сая төгрөгийн авлага үүсгээсэнд төлбөрийн акт тогтоосон.
- 19 сумын сум хөгжүүлэх сангийн хугацаа хэтэрсэн нийт 2,756.1 сая төгрөгийн зээлийн авлагыг барагдуулах арга хэмжээ авч ажиллах, албан шаардлагыг сумдын Засаг дарга нарт хүргүүлээ.

3.5.3 Урьдчилж төлсөн зардал

Ундарга ОНӨААТҮГ нь урьдчилгаа дансанд 4.6 сая төгрөгийн үлдэгдэл тайлагнасан нь тайланд хугацаанд ажилчдад олгосон цалингийн урьдчилгааг суутган тооцоогүйтэй холбоотой үүссэн байна.

3.5.4 БАРАА МАТЕРИАЛ

Бараа материал дансны эхний үлдэгдэл **6,997.9** сая төгрөг, эцсийн үлдэгдэл **8,407.0** сая төгрөг болж, **1,409.1** сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №7. Бараа материалын үлдэгдэл

/сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Тусгай зориулалттай материал	1,115.0	1,209.4	94.4
Эм боох материал	349.0	1,064.8	715.7
Бэлэн бүтээгдэхүүн	1.5	1.1	(0.4)
Бичиг хэргийн материал	230.7	237.1	6.4
Аж ахуйн материал	4,154.1	4,637.3	483.2
Сэлбэг хэрэгсэл	144.1	218.5	74.5
Түлш шатах тослох материал	137.1	115.3	(21.7)
Барилгын засварын материал	225.9	241.3	15.5
Хүнсний материал	28.4	64.6	36.3
Бусад хангамжийн материал	350.5	356.1	5.6
Мал амьтад	261.6	261.3	(0.3)
Дүн	6,997.9	8,407.0	1,409.1
<i>Үүнээс, байгууллагын төрлөөр</i>			
Төсөвт байгууллага	6,832.1	8,192.0	1,359.9
Төсөл/сан	31.1	1.5	(29.6)
ОНӨҮГ	134.7	213.5	78.8
Дүн	6,997.9	8,407.0	1,409.1

Эх сурвалж: Аймгийн ТЕЗ-ийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Нийт бараа материалын 97.4 хувь буюу 8,192.0 сая төгрөгийг төсөвт байгууллагын, 0.1 хувь буюу 1.5 сая төгрөгийг төсөл сангийн, 2.5 хувь буюу 213.5 сая төгрөгийг ОНӨҮГ-ын бараа материал тус тус эзэлж байна.

Тайлант онд бараа материал нь төсвийн хөрөнгөөр худалдан авсан 10,627.2 сая төгрөг, үнэ төлбөргүй хандиваар авсан 3,884.6 сая төгрөг, шилжүүлэн авсан 652.1 сая төгрөг, бусад эх үүсвэрээс авсан 1,003.4 сая төгрөг нийт 16,167.3 сая төгрөгөөр нэмэгдэн, үйл ажиллагаанд зарцуулсан 14,080.6 сая төгрөг, бараа материалын шилжүүлгээр болон бүтцийн өөрчлөлтөөр бусдад шилжүүлсэн 47.7 сая төгрөг, малын нас дэвшил болон акталж устгасан зэрэг бусад байдлаар 629.8 сая төгрөг нийт 14,758.1 сая төгрөгөөр хасагдсан байна.

Аймгийн ТЕЗ-ийн тайлангаарх бараа материалын өсөлтөд ковид цар тахалтай холбоотойгоор сумдын ЭМТ-үүд эм, эмнэлгийн хэрэгсэл холбогдох материалыг нөөцөлж, бэлтгэсэн зэрэг нь голлон нөлөөлсөн байна.

Аудитын илрүүлэлт

2021 оны санхүүгийн тайлангийн аудитаар бараа материалын данстай холбоотой дараах зөрчлүүд илэрсэн байна.

- Эрдэнэбулган сумын хүүхдийн 5-р цэцэрлэг нь 1.3 сая, Эрдэнэбулган хүүхдийн 6-р цэцэрлэг 1.3 сая, Ихтамир сумын хүүхдийн цэцэрлэг 0.7 сая, Цэнхэр сумын хүүхдийн цэцэрлэг 4.7 сая, Эрдэнэмандал сумын хүүхдийн цэцэрлэг 3.2 сая төгрөгийн хүнсний материалыг тус тус нөөцөлж, зарцуулагдаагүй үлдэгдлийг төвлөрүүлээгүй нийт 11.2 сая төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоосон байна.
- Төвшрүүлэх сумын ЗДТГ нь 1.0 сая, Жаргалант сумын ЗДТГ 0.9 сая, Хашаат сумын соёлын төв 0.8 сая, Батцэнгэл сумын ЗДТГ 1.9 сая, Өндөр-Улаан сумын соёлын төв нь 0.5 сая, Чулуут сумын ЭМТ 1.5 сая төгрөгийн түлээ нүүрсийг тус тус нөөцөлж, төсвийн зарцуулагдаагүй үлдэгдлийг төвлөрүүлээгүй нийт 6.6 сая төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоосон.
- Хотонт сумын хүүхдийн цэцэрлэг 14.5 сая, Булган сумын хүүхдийн цэцэрлэг 1.4 сая төгрөгийн бараа материалын тайланг нэг бүрийн үнэ, нэр төрлөөр гаргаагүй зөрчил илэрсэнд зөрчлийг арилгуулах албан шаардлага хүргүүлээ.
- Хотонт сумын ЭМТ 0.9 сая, Ундарга ОНӨААТҮГ нь 2.1 сая төгрөгийн бараа материалыг тус тус шууд зардлаар бүртгэж тайлагнасан зөрчлийг давтан гаргахгүй байх зөвлөмж хүргүүлээ.
- Тариат сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны жилийн эцсийн эд хөрөнгийн тооллогоор нийт 11.6 сая төгрөгийн эм, боох материал дутагдсаныг санхүүгийн тайланд тусгаагүй зөрчил илэрснийг таслан зогсоох давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлээ.
- Цахир сумын ЭМТ нь 1.0 сая төгрөгийн шатахууны талоныг үрэгдүүлсэн зөрчил илэрсэнд төлбөрийн акт тогтоолоо.
- Чулуут сумын ЕБС нь тайлант онд нийт 49.5 сая төгрөгийн худалдан авалт хийснээс 17.9 сая төгрөгийн хүнсний материалыг тендер худалдан авах ажиллагаа зохион байгуулахгүйгээр шууд худалдан авалт хийсэн зөрчил илэрсэнд зөрчлийг таслан зогсоох арилгуулах албан шаардлага хүргүүлсэн.
- Цахир сумын Соёлын төв нь 0.8 сая төгрөгийн нүүрсний үлдэгдлийг зөрүүтэй тайлагнасан зөрчил илэрсэнд зөрчлийг арилгуулах албан шаардлага хүргүүлээ.

3.5.5 НӨӨЦИЙН БАРАА

Нөөцийн бараа дансны эхний үлдэгдэл **80.4** сая төгрөг, эцсийн үлдэгдэл **475.9** сая төгрөг болж, **395.5** сая төгрөгөөр өссөн нь сумдууд болон аймгийн мал хамгаалах санд өвөлжилтийн бэлтгэл ажилтай холбоотой өвс тэжээл нөөцөлсөн, мөн малын халдварт өвчин шүлхий гарсантай холбоотойгоор нэмэгдсэн байна.

Хүснэгт №8. Нөөцийн барааны үлдэгдэл

/сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Нөөцийн бараа	80.4	475.9	395.5
Дүн	80.4	475.9	395.5
Төсвийн байгууллага	50.4	243.0	162.6
Төсөл сан	30.0	232.9	202.9
Дүн	80.4	475.9	395.5

Эх сурвалж: Аймгийн ТЕЗ-ийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Нөөцийн бараа материалын данс нь 80.4 сая төгрөгийн эхний үлдэгдэлтэй ба тайлант онд төсвийн хөрөнгөөр худалдан авсан 258.5 сая төгрөг үнэ төлбөргүй хандиваар авсан 249.8 сая төгрөг, бусад эх үүсвэрээс авсан 15.0 сая төгрөг нийт 523.3 сая төгрөгөөр нэмэгдэж, тайлант онд үйл ажиллагаанд зарцуулсан 127.8 сая төгрөгөөр хасагдаж, эцсийн үлдэгдэл 475.9 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.

3.5.6 Бусад эргэлтийн хөрөнгө

Бусад эргэлтийн хөрөнгийн эхний үлдэгдэл **382.0** сая төгрөг, эцсийн үлдэгдэл **247.5** сая төгрөг болж, 134.5 сая төгрөгөөр буурсан нь дараах шалтгаантай байна. Үүнд:

- Орон нутгийн өмчийн газрын хөрөнгө 136.1 сая төгрөгөөр буурсан нь дуусаагүй үйлдвэрлэл дансанд бүртгэлтэй хог хаягдал дахин боловсруулах үйлдвэрийн тоног төхөөрөмжийг Хот тохижилт үйлчилгээний газар руу шилжүүлсэн,
- Цөм сүрэг үржлийн төвийн хөрөнгө 1.6 сая төгрөгөөр өссөн нь малын нас дэвшилт төлийн орлоготой холбоотой байна.

Орон нутгийн төсвийн хөрөнгөөр санхүүжүүлсэн тайлант онд ашиглалтанд ороогүй, он дамжин хэрэгжиж байгаа 247.5 сая төгрөгийн дараах хөрөнгүүд бүртгэлтэй байна. Үүнд:

- Аймгийн 19 суманд авсан бог малын арьс боловсруулах тоног төхөөрөмж 159.8 сая төгрөг
- Аймгийн Цөм сүргийн үржлийн төв ОНӨААТҮГ-ын 1 жилээс дээш хугацаатай авлага 87.7 сая төгрөгийн хөрөнгө тус тус бүртгэлтэй байна.

3.5.7 Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгө дансны эхний үлдэгдэл **194,475.1** сая төгрөг, эцсийн үлдэгдэл **217,162.6** сая төгрөг болж **22,687.5** сая төгрөгөөр өссөн байна.

Нийт үндсэн хөрөнгийн 95.7 хувь буюу 207,888.7 сая төгрөгийг биет хөрөнгө, 4.0 хувь буюу 8,460.1 сая төгрөгийг биет бус хөрөнгө, 0.3 хувь буюу 177.9 сая төгрөгийг бусад хөрөнгө тус тус эзэлж байна.

Хүснэгт №9. Үндсэн хөрөнгийн үлдэгдэл

/сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Биет хөрөнгө	186,276.1	208,524.6	22,248.5
Биет бус хөрөнгө	8,007.0	8,460.1	453.1
Бусад хөрөнгө	192.0	177.9	(14.1)
Дүн	194,475.1	217,162.6	22,687.5
Үүнээс, байгууллагын төрлөөр			
Төсөвт байгууллага	177,329.7	207,888.7	30,559.0
Төсөл/сан	251.7	244.6	(7.1)
ОНӨҮГ	16,893.7	9,029.3	(7,864.4)
Дүн	194,475.1	217,162.6	22,687.5

Эх сурвалж: Аймгийн ТЭЗ-ийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Нийт үндсэн хөрөнгийн 95.7 хувь буюу 208,046.3 сая төгрөгийг төсөвт байгууллагын, 0.1 хувь буюу 244.6 сая төгрөгийг төсөл сангийн, 4.2 хувь буюу 9,029.3 сая төгрөгийг ОНӨҮГ-ын үндсэн хөрөнгө тус тус эзэлж байна.

Тайлант онд үндсэн хөрөнгө нь төсвийн хөрөнгөөр бэлтгэсэн 1,855.7 сая төгрөг, балансаас баланст шилжүүлэн авсан 10,557.3 сая төгрөг, үнэ төлбөргүй хандиваар авсан 13,684.6 сая төгрөг, бусад эх үүсвэрээс авсан 20,723.2 сая төгрөгөөр нэмэгдэн, балансаас баланст шилжүүлсэн 12,377.5 сая төгрөг, акталсан 4,054.5 сая төгрөг, худалдсан 1.5 сая төгрөг, бусад байдлаар 1,488.1 сая төгрөг нийт 17,922.6 сая төгрөгөөр хасагдсан байна.

Аймгийн ТЭЗ-ийн нэгтгэсэн тайлангаарх үндсэн хөрөнгө дансны өсөлтөд тайлант онд Тариат болон Эрдэнэмандал сумдын ЭМТ-үүд орон нутагт шилжиж, санхүүгийн тайлангаа нэгтгүүлсэн, улс орон нутгийн төсвийн хөрөнгөөр хэрэгжсэн хөрөнгө оруулалтын ажлуудыг хүлээн авч бүртгэл тайланд тусгасан зэрэг нь голлон нөлөөлсөн байна. Тухайлбал: Эрдэнэбулган сумын 1-р сургуулийн 3,395.0 сая төгрөгийн, 3-р сургуулийн 624.8 сая төгрөгийн өртөгтэй өргөтгөлийн барилга, Эрдэнэмандал сумын

төвийн шинэчлэлийн ажил 3,995.0 сая, Хануйн голын бетон гүүр 3,498.0 сая төгрөгийн тус тус өртөгтэй хөрөнгүүдийг ашиглагч байгууллага бүртгэлдээ тусгажээ.

Биет хөрөнгө дансанд бүртгэлтэй байгаа Дуусаагүй барилга байгууламж дансанд 420.4 сая төгрөгийн дараах үндсэн хөрөнгүүд байна. Үүнд:

- Улсын төсвийн хөрөнгөөр санхүүжигдсэн 117.8 сая төгрөгийн бодит гүйцэтгэлээр бүртгэлд тусгасан дуусаагүй барилга нь Аймгийн ОНӨГ-т,
- Аймгийн ОНХС-аас санхүүжигдсэн 6.3 сая төгрөгийн худаг 2014 оноос хойш Хангай сумын ЗДТГ-т,
- Халуун ус, саун засварлах 38.1 сая төгрөгийн хөрөнгө Хайрхан сумын ЗДТГ-т,
- Жаргалант сумын давсан орлогоос санхүүжигдсэн 218.6 сая төгрөгийн ЗДТГ-ын барилга 2019 оноос хойш Жаргалант сумын ЗДТГ-т,
- Улсын төсвийн хөрөнгөөр санхүүжигдсэн 25.3 сая төгрөгийн эхчүүдийн амрах байр 2017 оноос хойш Төвшрүүлэх сумын ЭМТ-д,
- Аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжигдсэн 14.1 сая төгрөгийн сумын төвийн худаг 2015 оноос хойш Цахир сумын ЗДТГ-т тус тус бүртгэлтэй байна.

Биет бус хөрөнгө дансанд 193.8 сая төгрөгийн програм хангамж, 8,401.1 сая төгрөгийн бусад биет бус хөрөнгө бүртгэлтэй байна. Нийт хуримтлагдсан элэгдэл 134.8 сая төгрөг байна.

Бусад хөрөнгө дансанд Цөм сүрэг үржлийн төвийн 177.9 сая төгрөгийн биологийн хөрөнгө буюу мал үндсэн хөрөнгөд бүртгэлтэй байна.

Аудитын илрүүлэлт:

2021 оны санхүүгийн тайлангийн аудитаар үндсэн хөрөнгийн данстай холбоотой дараах зөрчлүүд илэрсэн. Үүнд:

- Нийт 25 төсөвт байгууллагуудын үндсэн хөрөнгийн дансанд ашиглалтын хугацаа дуусч элэгдлээ бүрэн нөхсөн, үлдэх өртөггүй 1626 нэр төрлийн 1,276.4 сая төгрөгийн хөрөнгө бүртгэлтэй байгаа зөрчил илэрсэнд ТБОНӨТХуулийн 31-р зүйлд заасны дагуу өмч хамгаалах байнгын зөвлөлөөр хэлэлцүүлэн ашиглах боломжтой хөрөнгийн хугацааг уртасгах, дахин үнэлэх, ашиглагдах хугацаа дууссан цаашид ашиглах боломжгүй үндсэн хөрөнгийг данснаас хасах арга хэмжээг авах зөвлөмжийг хүргүүлээ.
- Тариат, Өгийнуур сумдын ЕБС, Хайрхан сумын ЗДТГ нь үндсэн хөрөнгийн дансанд 32 нэр төрлийн 19.1 сая төгрөгийн бараа материалын шинж чанартай хөрөнгийг бүртгэсэн зөрчил илэрсэнд үнэн зөв бүртгэж тайлагнаж байх зөвлөмжийг хүргүүлээ.
- Эрдэнэбулган сумын Хүүхдийн 3-р цэцэрлэг нь 2.5 сая төгрөгийг үнэ бүхий ширээ сандал, Эрдэнэбулган сумын Хүүхдийн 8-р цэцэрлэг нь 11.2 сая төгрөгийн үнэ бүхий компьютер, техник хэрэгслийг тус тус худалдан авсан бөгөөд тавилга, эд хогшил тоног төхөөрөмжийг хүлээн авахдаа комисс томилж, бүрэн бүтэн байдал, чанарын баталгаа, иж бүрэн байдлыг шалгаагүй, комисс томилсон шийдвэр, комиссын хурлын тэмдэглэл, хүлээн авсан акт зэргийг үйлдэж баталгаажуулаагүй зөрчил илэрсэнд зөрчлийг арилгуулах албан шаардлага хүргүүлээ.
- Эрдэнэбулган сумын Хүүхдийн 10-р цэцэрлэг нь 18.9 сая төгрөгийн өртөг бүхий барилгын урсгал засварын ажлыг ААН-тэй гэрээ байгуулан гүйцэтгүүлсэн бөгөөд захиалагч барилгын засварын ажлыг хүлээн авахдаа комисс томилж, засварын чанарын байдал, явцын ажлын гүйцэтгэлийг шалгаагүй, комисс томилсон

шийдвэр, комиссын хурлын тэмдэглэл, хүлээн авсан акт зэрэг баримт бичгийн иж бүрдлийг үйлдэж баталгаажуулаагүй зөрчил илэрсэнд зөрчлийг арилгуулах албан шаардлага хүргүүлээ.

- Чулуут сумын Эрүүл мэндийн төв нь 22.1 сая төгрөгийн үндсэн хөрөнгийн худалдан авахдаа харьцуулалтын аргаар сонгон шалгаруулалт, тендер худалдан авалтыг зохион байгуулаагүй зөрчил илэрсэнд зөрчлийг арилгуулах албан шаардлага хүргүүлээ.

3.5.8 ӨР ТӨЛБӨР

Өр төлбөр дансны эхний үлдэгдэл **12,407.9** сая төгрөг, эцсийн үлдэгдэл **12,546.7** сая төгрөг болж, **138.8** сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №.10 Нийт өр төлбөрийн үлдэгдэл

/сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өссөн+ Буурсан -
Богино хугацаат өр төлбөр дүн	1,236.9	1,331.2	94.3
Богино хугацаат зээлийн өглөг	5.1	5.1	-
Өглөг	1,191.2	354.4	(836.8)
Ажилчидтай холбогдсон өглөг	11.1	160.6	149.5
Бараа үйлчилгээний зардлын өглөг	0.4	191.7	191.3
Хөрөнгө бэлтгэхтэй холбогдсон өглөг	299.1	2.1	(297.0)
Бусад өглөг	880.6	841.4	(39.2)
Байгууллагад төлөх өглөг	851.2	815.2	(36.0)
Хувь хүмүүст төлөх өглөг	0.5	3.3	2.8
Татварын өглөг	27.2	18.9	(8.3)
НДШ-ийн өглөг	1.7	4.0	2.3
Урьдчилж орсон орлого	40.6	130.3	89.7
Урт хугацаат өр төлбөр дүн	11,171.0	11,215.5	44.5
Урт хугацаат зээл	11,171.0	11,215.5	44.5
Дүн	12,407.9	12,546.7	138.8
Үүнээс, байгууллагын төрлөөр			
Төсөвт байгууллага	854.6	9,826.6	8,972.0
Төрийн сан	20.8	20.8	-
ОНӨҮГ	11,532.5	2,699.3	(8,833.2)
ДҮН	12,407.9	12,546.7	138.8

Эх сурвалж: Аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Нийт өр төлбөрийн 78.3 хувь буюу 9,826.6 сая төгрөг нь төсөвт байгууллагын, 21.5 хувь буюу 2,699.3 сая төгрөг нь ОНӨҮГ-ын, 0.2 хувь буюу 20.8 сая төгрөг төрийн сангийн өр төлбөр байна.

Төсөвт байгууллагын өр төлбөр

- Төсөвт байгууллагын өр төлбөрийн 88.4 хувь нь Ундарга ОНӨГ-аас Аймгийн ИТХ-ын Архангай аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2021 оны 04 дүгээр сарын 16-ны өдрийн 14 дүгээр тогтоолоор аймгийн ОНӨГ-т шилжүүлсэн гадаад валютаар хийгдсэн 2021 оны 12 дугаар сарын 31-ны байдлаар 8,687.4 сая төгрөгийн үнэлгээ бүхий Азийн хөгжлийн банкны дамжуулан зээл байна.
- Төсөвт байгууллагын өр төлбөрийн 7.8 хувь буюу 765.9 сая төгрөг нь нэгдсэн халаалт болон цэвэр бохир усны төлбөртэй холбоотой өр байна. Үүнд: Тариат сумын Соёлын төв- 15.1 сая төгрөг, Өлзийт сумын ЕБС – 514.1 сая төгрөг, Соёлын төв -111.8 сая төгрөг,

Эрдэнэбулган сумын 1-р сургуулийн 320 хүүхдийн сургуулийн өргөтгөлийн барилга 2021 онд шинээр ашиглалтанд орж, цэвэр бохир усны төлбөр 2021 оны 02 дугаар сарын 01-ний өдрөөс нэмэгдсэнтэй холбоотойгоор халаалт, цэвэр бохир усны төлбөр нийт 111.8 сая төгрөг, 3-р сургуулийн урлаг заалны барилга 2021 онд шинээр ашиглалтанд орсноор халаалтын төлбөр 4.5 сая төгрөг, Спортын төрөлжсөн сургууль 2021 оны төсвийн тодотголоор халаалтын төлбөрийн төсөв дутуу батлагдсанаас 8.6 сая төгрөгийн халаалтын өр төлбөр тус тус үүссэн байна.

- ✓ Тайлант онд үүссэн төсөвт байгууллагын өр төлбөрийн 2.2 хувь буюу 218.1 сая төгрөг нь сумдын ЭМТ-ийн өр төлбөр бөгөөд Ковидын цогц тусламж үйлчилгээний санхүүжилт Эрүүл мэндийн даатгалын сангаас бүрэн холбоотой байна. Үүнд: Эрдэнэмандал сумын ЭМТ – 100.5 сая, Жаргалант сумын ЭМТ -54.4 саяг, Хайрхан сумын ЭМТ – 0.1 сая, Өгийнуур сумын ЭМТ – 45.6 сая, Цэнхэр сумын ЭМТ-2.4 сая,Төвшрүүлэх сумын ЭМТ 1.9 сая, Өрхийн ЭМТ-12.9 сая төгрөгийн тус тус байгууллагад төлөх өглөгтэй байна.

Төрийн сангийн өр төлбөр

- ✓ Төрийн сангийн өр төлбөрт бусад урьдчилж орсон орлогоор тайлагнагдсан 15.7 сая төгрөг нь татварын цахим систем шинэчлэгдсэнтэй холбогдон данс андуурч Эрдэнэмандал сумын ерөнхий орлогын дансанд 2019 онд төвлөрсөн мөнгө одоог хүртэл үлдэгдэлтэй санхүүгийн тайланд бүртгэлтэй байна.
- ✓ УАГ-аас өгсөн албан шаардлагын дагуу “Хөдөөгийн ядуурлыг бууруулах төсөл”-ийн нэгжээс иргэдэд олгосон 52.1 сая төгрөгийн зээлээс 47.0 төгрөгийг барагдуулж, 5.1 сая төгрөгийн үлдэгдэлтэй байгааг Аймгийн ерөнхий орлогын дансанд тайлагнасан байна.

Тайлант онд дээрх 5.1 сая төгрөгийн өр төлбөрийг барагдуулах талаар арга хэмжээг авч ажиллаагүй байгаа тул аудитаас аймгийн засаг даргад өр төлбөрийг барагдуулан ажиллах албан шаардлагыг хүргүүлэхээр шийдвэрлэлээ.

ОНӨҮГ-ын өр төлбөр

- ✓ Аймгийн ЦСҮТ ОНӨҮГ нь 3.4 сая төгрөгийн татварын өглөгтэй ажилласан.
- ✓ “Архангайд үйлдвэрлэв” ОНӨААТҮГ нь 10.3 сая төгрөгийн татварын өглөг, 25.1 сая төгрөгийн урьдчилж орсон түрээсийн барьцаа дэнчин нийт 35.4 сая төгрөгийн өр төлбөртэй байна.
- ✓ “Ар Ус Ундарга” ХХК ОНӨҮГ-ын 121.9 сая төгрөгийн өр төлбөрийн 111.3 сая төгрөг нь байгууллагад төлөх өглөг, 4.0 сая төгрөг нь татварын өглөг, 4.5 сая төгрөг нь урьдчилж орсон орлого, 2.1 сая төгрөг нь хөрөнгө бэлтгэхтэй холбогдсон өглөг байна. Байгууллагад төлөх өглөг нь усны үнийн хөнгөлөлт, чөлөөлөлтөд хамрагдсан 18 сумдад хуваарилах өр төлбөрийн үлдэгдэл байна.
- ✓ Чулуутын ахуй үйлчилгээний төв нь байгууллагад төлөх өглөг 5.1 сая төгрөгийн өр, хувь хүмүүст төлөх 0.2 сая төгрөгийн өр, 1.1 сая төгрөгийн татварын өр, 3.9 сая төгрөгийн НДШ-ийн өр нийт 10.4 сая төгрөгийн өр төлбөртэй ажилласан байна.

Урт хугацаат зээлийг задалж харуулбал:

- 2004-2010 онуудад хэрэгжсэн нийтийн аж ахуйг сайжруулах 2 үе шаттай төслийн хүрээнд хэрэгжсэн 2,110.7 сая төгрөгийн зээл /Архангай аймгийн ЗДТГазар OL-1907MON-08 зээлийн гэрээний дугаартай/.Тус зээл нь 2010-2028 оны хооронд төлж дуусахаар байгаа бөгөөд одоог хүртэл төлөлт хийгдээгүй хэвээр байна.
- 2016 онд нийлүүлэгдсэн 118.3 сая төгрөгийн бохирын машины зээл /Архангай аймгийн ЗДТГазар OL-2301MON-1 зээлийн гэрээний дугаартай/

- Архангай аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2021 оны 04 дүгээр сарын 16-ны өдрийн 14 дүгээр тогтоолоор “Ар Ус Ундарга” ХХК-ийн өмчид бүртгэлтэй “Аймгийн төвийн цэвэрлэх байгууламж болон бусад туслах үйлчилгээ” ажлын хүрээнд 24-н нэр төрлийн барилга байгууламжийн ажил, холбогдон гарсан зардал нийт 8,687.4 сая төгрөгийн хөрөнгө болон зээлийг аймгийн Орон нутгийн өмчийн газарт шилжүүлэн бүртгэсэн байна. /Архангай аймгийн ЗДТГазар OL3388MON-1 зээлийн гэрээний дугаартай/
- Ундарга ОНӨААТҮГ-ын хөрөнгө бэлтгэхтэй холбогдсон өглөг нь тайлант онд 2.1 сая төгрөгөөр тайлагнагдаж өмнөх оноос 297.0 сая төгрөгөөр буурсан нь Монгол улсын Засгийн газар, Азийн хөгжлийн банкны хооронд 2002 оны 9 дүгээр сарын 05-ны өдөр байгуулсан гэрээний хүрээнд хийгдсэн 299.0 сая төгрөгийн ажлын нэг хэсгийг бүртгэсэн бөгөөд үүнийг өмнөх аудитаар дансны өглөгт бүртгэснийг залруулж, урт хугацаат өр төлбөрийн бусад хэсэг гэсэн дансанд бүртгүүлсэн байна.

Аудитын илрүүлэлт

2021 оны санхүүгийн тайлангийн аудитаар өр төлбөрийн данстай холбоотой дараах зөрчлүүд илэрсэн. Үүнд:

- Өлзийт сумын соёлын төв нэгдсэн халаалтад шилжсэнтэй холбоотойгоор 111.8 сая төгрөгийн, Тариат сумын соёлын төв 15.1 сая төгрөгийн өр төлбөртэй ажилласанд аудитаас өр төлбөрийг барагдуулах холбогдох арга хэмжээг авч ажиллах зөвлөмж хүргүүлээ.
- Эрдэнэмандал сумын ЭМТ нь ЭМДС-ийн дутуу санхүүжилттэй холбоотой 100.5 сая төгрөгийн өр төлбөр үүсгэсэн зөрчилд аудитаас зөрчлийг арилгах зөвлөмж хүргүүлээ.
- Хайрхан сумын ЭМТ үйлдвэрчний эвлэлийн 0.1 сая төгрөгийн өр төлбөрийг барагдуулаагүй, Өгийнуур сумын ЭМТ нь 45.6 сая төгрөгийн эмийн өртэй, Төвшрүүлэх сумын ЭМТ нь тайлант онд нийгмийн даатгалын шитгэлийг буруу тооцоолон 1.9 сая төгрөгийн шитмгэлийн өглөг үүсгэсэн зэрэг зөрчилд аудитаас зөрчлийг арилгуулах албан шаардлага хүргүүлээ.
- Орон нутгийн өмчийн газар нь 0.5 сая төгрөгийн орон сууцны түрээсийн өртэй ажилласанд аудитаас зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлээ.
- Өлзийт ЕБС нь нэгдсэн тайлаалтанд шилжсэнтэй холбоотойгоор 514.0 сая төгрөгийн халаалтын өртэй бөгөөд энэ нь 2018 оноос эхлэн үүссэн тул аудитаас өр төлбөрийг барагдуулахад холбогдох арга хэмжээг авч ажиллах албан шаардлага хүргүүлэн ажиллалаа.
- Сумын ТТЗ-ийн нэгдсэн тайлангийн аудитаар Чулуут сум 11.6 сая төгрөгийн, Эрдэнэбулган сум 143.2 сая төгрөгийн, Өлзийт сум 625.9 сая төгрөгийн, Эрдэнэмандал сум 116.2 сая төгрөгийн, Тариат сум 15.1 сая төгрөгийн, Цахир сум 34.2 сая төгрөгийн нийт 946.2 сая төгрөгийн 6 зөрчилд Төсвийн тухай хуулийн 6.4.8 дахь заалтыг мөрдөж, сумын удирдлагын зүгээс өр төлбөрийг барагдуулах талаар тодорхой арга хэмжээ авч ажиллах зөвлөмж хүргүүлэн ажилласан.

3.5.9 ЗАСГИЙН ГАЗРЫН ХУВЬ ОРОЛЦОО

Засгийн газрын хувь оролцоо дансны эхний үлдэгдэл **208,669.6** сая төгрөг, эцсийн үлдэгдэл **240,586.9** сая төгрөг болж, **31,917.3** сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №11 Цэвэр хөрөнгө өмчийн дансны үлдэгдэл

/сая төгрөг/

**Архангай аймгийн ТЭЗ-ийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд
хийсэн санхүүгийн аудитын тайлан**

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт/+, бууралт /-/
Засгийн газрын хувь оролцоо	208,669.6	240,586.9	31,917.3
Засгийн газрын оруулсан капитал	57,480.8	58,477.5	996.7
Өмч /төрийн/ /ТӨҮГ/	4,704.6	4,651.9	(52.7)
Эздийн өмчийн бусад хэсэг /ТӨҮГ/	3,414.9	3,414.9	-
Хуримтлагдсан үр дүн	96,927.1	126,118.6	29,191.5
Өмнөх үеийн үр дүн	93,693.9	98,393.6	4,699.7
Тайлант үеийн үр дүн	3,233.2	27,725.0	24,491.8
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	46,142.2	47,924.0	1,781.8
Дүн	208,669.6	240,586.9	31,917.3
Үүнээс, байгууллагын төрлөөр			
Төсөвт байгууллага	192,566.9	219,836.8	27,269.9
Төсөл, сан	3,242.0	6,731.0	3,489.0
Төрийн сан	6,743.3	6,819.1	75.8
ОНӨҮГ	6,117.4	7,200.0	1,082.6
Дүн	208,669.6	240,586.9	31,917.3

Эх сурвалж: Аймгийн ТЭЗ-ийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Засгийн газрын хувь оролцоо данс өсөлтөд Тариат болон Эрдэнэмандал сумын сум дундын эмнэлгийг Эрүүл мэндийн сайдын 2019 оны А/540 дугаар тушаалын дагуу А зэрэглэлийн эрүүл мэндийн төв болгон өөрчилж, санхүүгийн тайлан нь орон нутагт нэгтгэгдсэн, Ундарга ОНӨААТҮГ нь Азийн хөгжлийн банкны зээлээр хэрэгжсэн “Аймгийн төвийн цэвэрлэх байгууламж болон бусад туслах үйлчилгээ” ажлын хүрээнд 24-н нэр төрлийн барилга байгууламжийг ОНӨГ-т шилжүүлж, холбогдон гарсан 1,262.4 төгрөгийн зардлыг өмнөх үеийн үр дүнд залруулсан, зарим байгууллагууд дахин үнэлгээ хийгдсэн хөрөнгө акталсан, тайлант үеийн үр дүн өссөнтэй холбоотой байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Орон нутгийн төсвийн орлого, зардлын төлөвлөлт

Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2021 оны 12 дугаар сарын 02-ний өдрийн хуралдаанаар төсвийн орлогыг нийт 9,685.1 сая төгрөгөөр баталж, Сангийн яамны хянасан орлогыг газрын дуудлага худалдааны орлогыг 97.1 сая төгрөг, төсөвт байгууллагын өөрийн орлогыг 57.5 сая төгрөг нийт 154.6 сая төгрөгөөр нэмэгдүүлсэн байна. Харин 14 суманд малын тоо толгойн албан татварыг 1,625.0 сая төгрөгөөр, Хотонт сум газрын дуудлага худалдааны орлогыг 56.6 сая төгрөгөөр, Булган сум ойн нөөц ашигласны төлбөрийн орлогыг 50.0 сая төгрөгөөр, 4-н сум төсөвт байгууллагын өөрийн орлогыг 25.7 сая төгрөгөөр, Өндөр-Улаан, Ихтамир сумдууд хог хаягдлын хураамжийн орлогыг 5.0 сая төгрөгөөр нийт 1,762.3 сая төгрөгөөр нэмэгдүүлж, Ихтамир сум улсын тэмдэгтийн хураамжийн орлогыг 3.0 сая төгрөгөөр бууруулан сумдын төсвийн орлого нийт 1,759.3 сая төгрөгөөр нэмэгдэж, орон нутгийн төсвийн орлого 11,444.3 сая төгрөгөөр төлөвлөгдсөн байна.

Архангай аймгийн ИТХ-урлын 2020 оны 12 дугаар сарын 04-ний өдрийн 09 тоот тогтоолоор орон нутгийн төсвийн суурь зарлагыг 23,172.0 сая төгрөг, тусгай зориулалтын шилжүүлэг болон бусад орлогыг 55,054.6 сая төгрөг буюу нийт зардлыг 78,226.6 сая төгрөгөөр баталсан байна. Тайлангийн жилд аймгийн 2021 оны төсөвт 2 удаа тодотгол хийгдэж Аймгийн ИТХ-ын 2021 оны 12 сарын 02-ны өдрийн “Аймгийн төсөвт зохицуулалт хийж

тодотгон батлах тухай” 07 дугаар тогтоолоор аймгийн төсвийн орлого, зарлагын тэнцлийг 81,613.6 сая төгрөгөөр баталсан байна. Харин ТЕЗ-ийн төсвийн гүйцэтгэлийн тайлангаарх нийт зарлагын төлөвлөгөөний дүн аймгийн ИТХурлаар баталсан дүнгээс 8,888.5 сая төгрөгөөр илүү тайлагнагдсан нь сумын ИТХурал бүрэн эрхийнхээ хүрээнд сум хөгжүүлэх сангийн төлөвлөгөөг 3,092.9 сая төгрөгөөр, сумын ОНХС-ийн урьд оны үлдэгдэл 671.9 сая төгрөгөөр, сумдын урьд оны үлдэгдэл 3,364.4 сая төгрөгөөр, орон нутгийн төсвийн орлогыг 1,759.3 сая төгрөгөөр тус тус нэмсэнтэй холбоотой байна.

3.6.2 Орон нутгийн төсвийн орлогын төлөвлөгөө, гүйцэтгэл

Архангай аймгийн ИТХ-ын 2021 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн 07 дугаар тогтоолоор тайлант онд 11,444.3 сая төгрөгийн татварын болон татварын бус орлого бүрдүүлэхээр төлөвлөснөөс гүйцэтгэлээр 15,189.9 сая төгрөгийн орлого төвлөрүүлж, төлөвлөгөөг 3,745.5 сая төгрөгөөр давуулан биелүүлсэн байна.

3.6.3 Төсвийн гүйцэтгэл

Аймгийн ТЕЗ-ийн тайлангийн төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1,726.2 сая төгрөг буюу 90.3 хувьтай байгаа нь урсгал зардлаас 2,936.4 сая төгрөг, хөрөнгийн зардлаас 3,980.1 сая төгрөг, сум хөгжүүлэх сангаас 1,859.4 сая төгрөгийг тус тус зарцуулаагүйтэй холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд 6,946.2 сая төгрөгийн орлого бүрдүүлснээс цалин, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэлийн зардалд 1,634.1 сая, байр ашиглалттай холбоотой зөрдөлд 30.1 сая, хангамж, бараа материалын зүрдалд 325.1 сая, эм боох материал, хоол хүнс, нормын хувцас худалдан авах зардалд 1,690.0 сая, эд хогшил, урсгал засварын зардалд 331.1 сая, албан томилолтын зардалд 11.8 сая, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөрт 397.7 сая, бараа үйлчилгээний бусад зардалд 1,204.9 сая, урсгал шилжүүлэгт 975.7 сая, хөрөнгийн зардалд 248.1 сая нийт 6,848.6 сая төгрөгийг зарцуулж, үлдэгдэл 97.6 сая төгрөгийг эрүүл мэндийн салбарын дансны үлдэгдэл байна. Нийт зардлын 65.1 хувь буюу 4,518.9 сая төгрөг нь Эрүүл мэндийн салбарын байгууллагууд, 25.2 хувь буюу 1,748.9 сая төгрөг нь орон нутгийн төсвийн байгууллагууд, 5.6 хувь буюу 392.9 сая төгрөг нь боловсрол соёлын байгууллага, 3.4 хувь буюу 238.1 сая төгрөг нь Газрын харилцаа барилга хот байгуулалтын газар, 0.7 хувь буюу 47.4 сая төгрөг нь Гэр бүл хүүхэд залуучуудын хөгжлийн газар зарцуулжээ.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Тайлангийн жилд аймгийн Засаг дарга Д.Золжаргал нь Монгол Улсын Ерөнхий сайдын 2021 оны 8 дугаар сарын 3-ны өдрийн 129 дугаар захирамжаар ажлаас чөлөөлөгдөж, Монгол Улсын Ерөнхий сайдын 2021 оны 8 дугаар сарын 27-ны өдрийн 139 дугаар захирамжаар М.Батжаргал аймгийн Засаг даргаар томилогдон ажиллаж байна.

Тайлант онд ковид цар тахалтай холбоотойгоор аймгийн засаг даргын нөөц хөрөнгийг 482.5 сая төгрөгөөр баталсныг 2021 оны 9 дүгээр сард хийгдсэн төсвийн

тодотголоор 902.3 сая төгрөгөөр нэмэгдүүлэн 1,384.8 сая төгрөгөөр баталж, гүйцэтгэлээр 1,003.4 сая төгрөгийг зарцуулсан байна.

Засаг даргын нөөц хөрөнгийн зарцуулалтыг Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалаар батлагдсан Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журмын дагуу авч үзвэл: Нийт зарцуулалтын 35.5 хувийг журмын 2.1.1 дэх заалтын хүрээнд ковид цар тахал болон өвөлжилтийн бэлтгэлд, 31.3 хувийг 2.1.4 дэх заалтын хүрээнд иргэд байгууллагаас тавьсан хүсэлтийг шийдвэрэлэхэд, 19.4 хувийг 2.1.5 дахь заалтын хүрээнд засаг дарга бүрэн эрхээ хэрэгжүүлэхтэй холбоотой нэг удаагийн шинжтэй арга хэмжээнд, 13.8 хувийг 2.1.6 дахь заалтын хүрээнд шагнал урамшуулал, нэг удаагийн буцалтгүй тусламж дэмжлэгт тус тус зарцуулжээ.

Аймгийн ИТХ-ын тогтоолоор гамшгаас хамгаалах арга хэмжээг хэрэгжүүлэх зардалд 1,226.5 сая төгрөг батлаж, 641.6 сая төгрөгийг зарцуулж 584.9 сая төгрөг нь зарцуулагдаагүй хэмнэгдсэн байна.

3.8 Аудитын гол асуудал

Төсвийн ерөнхийлөн захирагчийн яамдын сайдуудтай байгуулсан гэрээний биелэлтийг жилийн эцсийн гүйцэтгэлээр авч үзэхэд сайдуудаас ирүүлсэн үнэлгээний дундажаар гэрээний хэрэгжилт 85.2 хувьтай дүгнэгджээ. Хүснэгтээр харуулбал:

Хүснэгт 12

№	Гэрээ байгуулсан сайд	Арга хэмжээний тоо	Биелэлтийн үнэлгээ							Биелэлтийн дундаж хувь
			100	90	70	50	30	0	Үнэлэх боломжгүй, хугацаа болоогүй	
1	Монгол улсын шадар сайд	33	22	0	8	0	3	0	0	86.3
2	МУ-ын сайд, ЗГ-ын хэрэг эрхлэх газрын дарга	23	0	19	2	0	0	0	2	88.0
3	Байгаль орчин аялал жуулчлалын сайд	49	4	32	4	1	0	1	7	85.9
4	Сангийн сайд	40	27	10	1	0	0	0	2	96.5
5	Хууль зүй, дотоод хэргийн сайд	19	12	2	3	0	1	0	1	90.0
6	Хүнс хөдөө аж ахуй хөнгөн үйлдвэрийн сайд	70	21	34	12	1	2	0	0	87.2
7	Батлан хамгаалах яам /МУ-ын шадар сайд/	37	0	30	2	2	0	0	3	86.4
8	Барилга, хот байгуулалтын сайд	77	0	46	21	4	2	0	4	80.4
9	Боловсрол соёл шинжлэх ухаан спортын сайд	63	0	50	5	3	1	0	4	85.2
10	соёлын сайд	40	20	5	6	0	6	0	3	82.4
11	Зам, тээврийн хөгжлийн сайд	37	0	27	8	0	0	0	2	85.4
12	Уул уурхайн хүнд үйлдвэрийн сайд	29	0	16	1	1	0	1	10	82.1
13	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд	54	12	15	15	3	6	1	2	75.5
14	Эрчим хүчний сайд	12	0	8	3	1	0	0	0	81.7
15	Эрүүл мэндийн сайд	53	0	39	12	1	0	0	1	84.6
16	Үндэсний хөгжлийн газрын дарга	16	0	8	2	0	0	0	6	86.0
НИЙТ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТОО		652	118	341	105	17	21	3	47	85.2

Төрийн аудитын байгууллагаас 2021-2022 онд гүйцэтгэх санхүүгийн тайлангийн аудитад баримтлах ерөнхий чиглэлийг МҮЕА-ын 2021 оны 12 дугаар сарын 10-ны А/111 тушаал батлагдсан. Тус чиглэлийн хүрээнд дараах асуудлуудыг авч үзлээ. Үүнд:

1. Эрүүл мэндээ хамгаалж эдийн засгаа сэргээх 10 их наядын цогц төлөвлөгөөнийн талаар

Эрүүл мэндээ хамгаалж эдийн засгаа сэргээх 10 их наядын цогц төлөвлөгөөнд тусгасан ажлуудыг аймаг орон нутагт тухай бүр хэрэгжүүлэн ажилласан бөгөөд дараах арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэхэд аймгийн төсвийн гамшгаас хамгаалах зардлын данснаас нийт 641.6 сая төгрөгийг зарцуулсан байна. Үүнд:

- Оношлуур, хувийн хамгаалах хэрэгсэл, эмийн багц худалдан авахад 279.9 сая төгрөг
- Онцгой комиссын шуурхай штаб эргүүл, пост ажиллуулахад 167.3 сая төгрөг
- Нийтийн худалдаа үйлчилгээний газрууд, орон сууц, нийтийн эзэмшлийн гудамж талбайд ариутгал халдваргүйтгэл хийхэд 7.5 сая төгрөг
- Сумдад дэмжлэг үзүүлэхэд 75.2 сая төгрөг
- Тусгаарлах байрны зардалд 51.8 сая төгрөг
- Цар тахлаас сэргийлэх сурталчилгаа сонин хэвлүүлэх, цахим мэдээллийн сан бий болгоход 18.8 сая төгрөг
- Малын гоц халдварт өвчинтэй тэмцэх хариу арга хэмжээнд 21.2 сая төгрөг
- Өвс тэжээлийн нөөц бүрдүүлэхэд 19.9 сая төгрөг

2. Эрүүл мэндийн салбарын шинэчлэлийн талаар

Монгол Улсын Их Хурлаар 2020 оны 8 дугаар сарын 28-нд баталсан Эрүүл мэндийн тухай хууль, Эмнэлгийн тусламж, үйлчилгээний тухай хууль, Эрүүл мэндийн даатгалын тухай хуульд орсон нэмэлт, өөрчлөлтийн хэрэгжилтийг хангах зорилгоор эрүүл мэндийн салбарын санхүүжилтийн шинэчлэлийг 2021 оны 1 дүгээр сарын 1-нээс эхлэн хэрэгжүүлж эхэлсэн. Үүнтэй холбоотойгоор аймгийн ТЕЗ-ийн харьяа 19 сумын ЭМТ-үүдийн нийт 196.2 сая төгрөгийн санхүүжилтийн үлдэгдлийг орон нутгийн төсвийн орлогын дансанд татан төвлөрүүлээгүй ба ЭМТ-үүд үлдэгдлээр тайлагнасан байна.

Сумдын ЭМТ-үүд болон Эрдэнэбулган сумын өрхийн ЭМТ-ийн санхүүгийн тайлангийн аудитаар коронавирусн халдварын эсрэг цогц тусламж үйлчилгээ буюу шинжилгээний сорьц авах, гэрээр үзүүлэх тусламж үйлчилгээ, хэвтүүлэн эмчлүүлэх тусламж үйлчилгээ, дархлаажуулалтын санхүүжилтийг холбогдох журмын дагуу олгосон, зарцуулсан эсэхэд аудитын горим сорилыг хэрэгжүүлэн ажилласан. Аудитаар ЭМТ-үүд болон Өрхийн ЭМТ-үүд нь коронавирусн халдварын эсрэг цогц тусламж үйлчилгээний санхүүжилттэй холбоотой ЭМДС-аас нийт 1,332.5 сая төгрөгийн санхүүжилт авах тооцоо үүсч, эм, эмчилгээний багц, халдвар хамгааллын хэрэгслийн зардлын нийт 218.1 сая төгрөгийн өр төлбөрийг тусгасан байна.

Санхүүгийн тайлангийн аудитад баримтлах ерөнхий чиглэлийн хүрээнд 19 сумын ЭМТ болон Эрдэнэбулган сумын 3 өрхийн ЭМТ-ээс анхан шатны эмнэлгийн короновирусын халдвараар өвчилсөн иргэдэд гэрээр үзүүлсэн тусламж, үйлчилгээний санхүүжилт, зарцуулалтын талаарх судалгааг авсан бөгөөд одоогоор судалгааг fas.audit.mn системээр нэгтгэж байна.

3. Коронавирус халдварт /ковид-19/-ын цар тахлын үед айл өрх, аж ахуйн нэгж, байгууллагад дэмжлэг үзүүлэх зарим арга хэмжээний тухай

Коронавирус халдварт /ковид-19/-ын цар тахлын үед айл өрх, аж ахуйн нэгж, байгууллагад дэмжлэг үзүүлэх зарим арга хэмжээний тухай” Монгол Улсын Засгийн газрын

2020 оны 211 дүгээр тогтоолын дагуу цэвэр, бохир усны хөнгөлөлт, чөлөөлөлтийн санхүүжилтийг Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалт үйлчилгээг зохицуулах зөвлөл /ХСУХАТАҮЗЗ/-өөс орон нутаг дахь тусгай зөвшөөрөл бүхий Ар Ус ундарга ОНӨҮГ-аар дамжуулан олгосон байна. Энэ хүрээнд 974.5 сая төгрөгийн санхүүжилт авахаар нэхэмжилснээс 779.1 сая төгрөгийг хүлээн авчээ. Санхүүжилттэй холбоотой 101.3 сая төгрөгийн авлагын үлдэгдлийг ХСАТАҮЗЗ-тэй тооцоо нийлж баталгаажуулсан байна. Харин сумдад дамжуулан олгох санхүүжилтийг өр төлбөрөөр бүртгэсэн ба тус өр төлбөрийн хоорондын тооцоог нийлж баталгаажуулаагүй зөрчил илэрсэнд зөрчлийг арилгуулах албан шаардлага хүргүүлээ. Энэхүү хөнгөлөлт чөлөөлөлтийн санхүүжилттэй холбоотой авлага, өр төлбөрийн дүнг аймгийн ТЭЗ-ийн санхүүгийн нэгтгэсэн тайланд нэгтгүүлсэн байна.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

Санхүүгийн тайлангийн аудитаар Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт болон Монгол Улсын Засгийн газрын *“Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай”* 43 дугаар тогтоолын хэрэгжилтийг шалгаж үр дүнг баримтжуулсан.

3.9.1 шилэн дансны хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагч нь тайлант хугацаанд шилэн дансны цахим хуудсанд оруулбал зохих 158 мэдээлэл байршуулахаас 103 мэдээллийг хугацаанд нь 44 мэдээллийг хугацаа хоцроож, 11 мэдээллийг огт байршуулаагүй байна. Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3-т “тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх”, 6 дугаар зүйлийн 6.1-6.10-д заасан “төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд, байгууллага, албан тушаалтан дараах мэдээллийг тогтмол мэдээлнэ...” гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчлийг арилгуулах, таслан зогсоох албан шаардлагыг хүргүүлээ.

Аудитын илрүүлэлт

ОНТЕЗ-ийн харьяа төсвийн шууд захирагчийн 156, сумын ТЭЗ-ийн 19, ОНӨҮГ-4 нийт 179 байгууллагуудын шилэн дансны мэдээллийг хянаж үзэхэд дараах зөрчлүүд илэрсэн. Үүнд:

1. Төсвийн шууд захирагчийн шилэн дансны талаар: 81 байгууллагатай холбоотой нийт 1322 мэдээллийг хугацаа хоцроон байршуулж, 2,042.2 сая төгрөгийн 105 мэдээллийг байршуулаагүй зөрчил илэрсэнд зөрчлийг арилгуулж, шилэн дансны хуулийн хэрэгжилтийг хангуулах үүднээс 46 албан шаардлага, 35 зөвлөмжийг тус тус хүргүүлсэн байна.
2. Сумын ТЭЗ-ийн шилэн дансны талаар: 19 сумын ТЭЗ-тай холбоотой нийт 481 мэдээллийг хугацаа хоцроон байршуулж, 107 мэдээллийг байршуулаагүй зөрчил илэрсэнд аудитаас зөрчлийг арилгуулж, шилэн дансны хуулийн хэрэгжилтийг

хангуулан ажиллах, 2 албан тушаалтанд сахилгын шийтгэл ногдуулах нийт 12 албан шаардлага, 7 зөвлөмжийг тус тус хүргүүлээд байна.

3. ОНӨҮГ-ын шилэн дансны талаар: Цөм сүргийн үржлийн төв, Архангайд үйлдвэрлэв, Чулуут ахуй үйлчилгээний төв, Ар Ус Ундарга ХХК ОНӨҮГ-ууд нь нийт 231 мэдээллийг хугацаа хоцроож, 127 мэдээллийг ил тод байршуулаагүй зэрэг зөрчил илэрсэнд зөрчлийг арилгуулж, шилэн дансны хуулийн хэрэгжилтийг хангуулан ажиллах, 1 албан тушаалтанд сахилгын шийтгэл ногдуулах нийт 4 албан шаардлагыг хүргүүллээ.

Дээрх зөрчлүүдээс үзэхэд аймгийн ТЕЗ-ийн харьяа байгууллагын 43.7 хувь буюу 104 байгууллагад шилэн дансны мэдээллийг хугацаа хоцроон мэдээлэх зөрчил давамгайлж байгаа нь хуулийн хэрэгжилтийг хангуулж ажиллах шаардлагатайг харуулж байна.

3.9.2 Бусад хууль тогтоомжийн хэрэгжилт

1. Тайланд онд Монгол Улсын Засгийн газрын “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай” 43 дугаар тогтоолыг мөрдөж ажиллахыг бүх шатны төсөв захирагчид даалгасан. Уг тогтоолын хэрэгжилтийг Аймгийн ТЕЗ-ийн харьяа байгууллагуудын санхүүгийн тайлангийн аудитаар шалгахад 810.1 сая төгрөгийн дараах зөрчил илэрсэн байна. Үүнд:
 - Төсвийн хэмнэлтийг 43 дугаар тогтоолын 1.1-т “үндсэн үйл ажиллагаатай холбоотой, зайлшгүй шаардлагатайгаас бусад бүх төрлийн зардал, арга хэмжээг тэвчиж, зардал гаргахгүй байх, батлагдсан төсөвт зардлын дүнд 10-аас доошгүй хувийн хэмнэлт гаргахаар тооцож, урсгал болон хөрөнгийн зардлыг төлөвлөн хуваарилах”, 1.8-т “Байгууллагын цахилгаан, дулааны эрчим хүч, цэвэр усны хэрэглээнд 20-иос доошгүй хувийн хэмнэлт гаргах”, 1.9-т “бичиг хэрэг, албан хэрэг хөтлөлтийг байгууллагын дотоод сүлжээнд цахим хэлбэрт шилжүүлэх замаар бичиг хэрэг, цаас, хувилагч, хэвлэгчийн хорны зэрэг зардлыг бууруулах” гэсэн заалтуудтай нийцүүлж үзэхэд 54 байгууллага 667.9 сая төгрөгийн хэмнэлтийг бий болгож ажиллаагүй,
 - 1.2-т “Шинээр ажлын чиг үүрэг, албан тушаал бий болгохгүй, орон тоог нэмэгдүүлэхгүй байх, өндөр насны тэтгэвэр тогтоолгож чөлөөлөгдсөн ажилтан, албан тушаалтны орон тоог царцааж, нөхөн томилгоо хийхгүйгээр цалингийн зардлыг хэмнэх” гэсэн заалттай нийцүүлж үзэхэд 5 байгууллагатай холбоотой 47.8 сая төгрөгийн,
 - 1.4-т “Энэ тогтоол батлагдахаас өмнө төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу зарлагдсанаас бусад автомашин, албан конторын тавилга, ... тоног төхөөрөмж, хэрэглэлийн худалдан авалтыг зохион байгуулахгүй байх” гэсэн заалттай нийцүүлж үзэхэд 21 байгууллагатай холбоотой 68.8 сая төгрөгийн,
 - 1.5-т “Салбарын хэмжээнд хийх сургалт, семинар, хурал, зөвлөгөөн болон газар дээрх хяналт-шалгалт зэргийг цахим хэлбэрээр зохион байгуулж, сургалт, семинар, хурал, зөвлөгөөн зэрэг арга хэмжээний болон дотоод албан томилолтын зардлыг хэмнэх,” гэсэн заалттай нийцүүлж үзэхэд сургалт семинар зохион байгуулж 25.6 сая төгрөгийн зардал гаргасан 2 байгууллагатай холбоотой зөрчил тус тус илэрсэнд 43 дугаар тогтоолыг хэрэгжүүлэн төсөвт зардлыг хэмнэж ажиллах албан шаардлагыг төсөвт байгууллагуудад хүргүүлсэн байна.

Шийдвэрлэсэн нь: Аймгийн засаг даргын зүгээс Засгийн газрын 2021 оны 43, 388 дугаар тогтоолуудыг орон нутагт хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж, төсвийг хэмнэлттэй зарцуулах арга хэмжээг авч ажиллах албан шаардлагыг хүргүүллээ.

2. Аймгийн Засаг даргын 2019 оны 10 дугаар 04-ний өдрийн “Аймгийн ЗДТГ-ын бүтэц, орон тоог шинэчлэн батлах тухай” А/517 тоот захирамж, аймгийн ЗДТГ-ын даргын 2020 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн “Аймгийн ЗДТГ-ын нийтлэг үйлчилгээний газрын бүтэц, орон тоог шинэчлэн батлах тухай” А/80 тоот тушаалаар батлагдсан орон тооноос 1 орон тоо буюу засаг даргын зөвлөхийн орон тоогоор илүү ажиллаж, цалинд 18.2 сая төгрөгийг олгосон байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-т “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж зарцуулах”, 16 дугаар зүйлийн 16.5.3 “Батлагдсан цалингийн сан, орон тооны хязгаарт багтан төсвийн байгууллагын ажиллагчдын орон тоо, цалин хөлсийг тогтоох”, Монгол Улсын ЗГ-ын 2016 оны “Аймгийн засаг даргын тамгын газрын бүтцийг шинэчлэн тогтоох тухай” 9 дүгээр тогтоолын “Орон нутгийн онцлог, нутаг дэвсгэрийн хэмжээ, хүн амын тоо, эдийн засаг, үйлдвэрлэлийн цар хүрээнээс хамааруулан Архангай,... аймгийн ЗДТГ-ыг 41 хүртэл орон тоотой байхаар тогтоосугай”, Монгол Улсын ЗГ-ын 2021 оны “Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай” 43 дугаар 1.2-т **“Шинээр ажлын чиг үүрэг, албан тушаал бий болгохгүй, орон тоог нэмэгдүүлэхгүй байх, ... цалингийн зардлыг хэмнэх”** гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчлийг арилгаж, холбогдох хууль, тогтоомжийн хэрэгжилтийг хангаж ажиллах албан шаардлагыг хүргүүллээ.

3.10 ӨМНӨХ ЗӨВЛӨМЖИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ТАЛААРХ ТАЙЛБАР, ТОДРУУЛГА

Аймгийн Засаг даргын 2021 оны 11 сарын 12-ны 01/1300 тоот, СТСХ-ийн даргын 2021 оны 11 сарын 15-ны өдрийн 08/1320 тоот, ОНӨГ-ын даргын 2021 оны 12 сарын 07-ны 555, 556 тоот албан бичгүүдээр ОНТЕЗ-ийн өмнөх жилийн санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмжийн хариуг ирүүлсэн байна. Үүнийг үнэлж үзэхэд хэрэгжилт 40 хувьтай байна гэж үзлээ. Хүснэгтээр дэлгэрэнгүй харуулбал: Хүснэгт 14

№	Зөвлөмжийн агуулга	Биелэлт	Хэрэгжилтийн байдал
1	Орон нутгийн өмчит ААН-ийн санхүүгийн тайлангийн аудитаар 4 хуулийн этгээд хамрагдаж, “Ар-Ус Ундарга” ОНӨААТҮГ, “Архангайд үйлдвэрлэв” болон Цөм сүрэг үржлийн төв ОНӨААТҮГ -ууд нь “Хязгаарлалттай” санал дүгнэлт, харин “Чулуут ахуйн үйлчилгээний төв” ОНӨААТҮГ-т “Санал дүгнэлт өгөхөөс татгалзсан” дүгнэлтийг авсан. Аудитаар нийт 7,986.2 сая төгрөгийн зөрчил илэрсэнд аудитаас: Хөрөнгө санхүүгийн үйл ажиллагаанд хяналт тавьж, мэргэжил арга зүйн удирдлагаар хангаж ажиллах	30%	ОНӨГ-ын 2021 оны 12 сарын 07-ны өдрийн 555, 556 тоот албан бичгүүдээр холбогдох арга хэмжээг авч зөвлөмжийн хэрэгжүүлэн ажиллаж байгаа талаар хариу ирүүлсэн байна. Өгсөн зөвлөмжийн биелэлтийг тооцож үзэхэд “Аялал жуулчлал мэдээллийн төв” ОНӨҮГ-ын татан буургаж, хөрөнгийг ОНӨГ шилжүүлэн бүртгэсэн. 2021 оны Санхүүгийн тайлангийн аудитаар “Ар Ус Ундарга” ОНӨААТҮГ, “Цөм сүрэг үржлийн төв”, “Архангайд үйлдвэрлэв” ОНӨҮГ-ууд нь “Хязгаарлалттай” санал дүгнэлт, харин “Чулуут ахуйн үйлчилгээний төв” ОНӨААТҮГ “Зөрчилгүй”

	• Үйл ажиллагааны үр дүнд дүн шинжилгээ хийж, ашигт ажиллагааг дээшлүүлэх талаар тодорхой арга хэмжээ авч ажиллах • Санхүүгийн ажилтнуудын мэргэжил ур чадварыг дээшлүүлэх, чадавхжуулах, сургах талаар тодорхой арга хэмжээг авч ажиллах зөвлөмжийг хүргүүлсэн.		дүгнэлт авч, Орон нутгийн өмчит ААН-ийн санхүүгийн тайлангийн аудитаар 4 хуулийн этгээд хамрагдаж, 369.2 сая төгрөгийн зөрчил илэрсэн байна.Өмнөх оноос зөрчлийн дүн буурсан байгаа тул зөвлөмжийн хэрэгжилтийг 30 хувьтай хэрэгжүүлсэн гэж үзлээ.
2	Аймгийн ТЭЗ-ийн нэгтгэсэн тайлангаар төсөвт байгууллагуудын нийт өр төлбөр 854.6 сая төгрөгөөр тайлагнагдсан ба үүний 97.2 хувь буюу 830.9 сая төгрөг нь нэгдсэн халаалтанд шилжсэнтэй холбоотой Тариат болон Өлзийт сумын төсөвт байгууллагуудад үүссэн халаалтын өр байна.Үүнд аудитаас: • Төсвийн тухай хуулийн хэрэгжилтийг хангуулж, өр төлбөрийг барагдуулах талаар Аймгийн ТЭЗ-ийн зүгээс тодорхой арга хэмжээ авч ажиллах • Цаашид шинээр өр төлбөр үүсгэхгүй байхад анхаарч, сумдын удирдлагуудад үүрэг чиглэл өгч ажиллах зөвлөмжийг хүргүүлсэн.	50%	Аймгийн Засаг даргын 2021 оны 11 сарын 12-ны өдрийн 01/1300 тоот албан бичгээр Тариат сумын ЕБС-ийн халаалтын 275.1 сая төгрөгийн өрийг, Өлзийт сумын Хүүхдийн цэцэрлэгийн халаалтын 26.9 сая төгрөгийн өрийг 2021 оны төсвийн тодотголоор бүрэн шийдвэрлэсэн тухай ирүүлсэн байна. Тайлант онд Тариат сумын ЕБС-ийн халаалтын өр бүрэн төлөгдсөн ч Соёлын төвийн халаалтын өр 5.1 сая төгрөгөөр нэмэгдсэн байна. Мөн Өлзийт сумын хүүхдийн цэцэрлэгийн халаалтын өрийг бүрэн барагдуулан бөгөөд ЕБС болон Соёлын төвийн халаалтын өр өмнөх өссөн байна.Иймд зөвлөмжийн хэрэгжилтийг 50 хувь хэрэгжүүлсэн гэж үзлээ.
Хэрэгжилт дутуу зөвлөмжийн тоо		2	Нийт хэрэгжилт 40%

3.11 АУДИТЫН ЯВЦАД ХЭРЭГЖҮҮЛСЭН ГОРИМ СОРИЛ, ТҮҮНИЙ ҮР ДҮН

Аудитын явцад хэрэгжүүлэх горим сорилыг төсвийн шатлалд хамаарах байгууллага, нэгж тус бүрээр төлөвлөж хэрэгжүүлсэн бөгөөд аудитын дүн, дүгнэлтийг нэгтгэсэн байдлаар үнэлж, гаргалаа.

Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд түүний харьяа 158 төсвийн байгууллага, 6 орон нутгийн өмчит үйлдвэрийн газар , 41 орон нутгийн тусгай сан, 19 сумын ТТЗ нийт 224 санхүүгийн тайланг нэгтгэсэн бөгөөд аймгийн засаг дарга данс, түүний хөтөлбөр арга хэмжээ, барьцаа хөрөнгө, техник хяналтын зардлын дансдын гүйлгээ хамрагдсан байна.

Төрийн аудитын байгууллагаас ТЭЗ-ийн харьяа байгууллагуудад хийсэн аудитаар 222 байгууллагын санхүүгийн тайлан хамрагдсанаас, 70 тайланг түүвэрт хамруулан, 152 төсөв захирагчийн тайланд санал дүгнэлт хүргүүлсэн. Хүснэгтээр харуулбал:

Хүснэгт 15

Байгууллагын төрөл	Байгууллага нэгжийн тоо				Гаргасан санал дүгнэлтийн хэлбэр		
	Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Зөрчилгүй	Хязгаарлалттай	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
		Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт	Аудит хийлгээгүй			
Төсвийн шууд захирагч	158	128	30	0	112	14	2
Төсөл сан	41	1	40	0	1	0	0
Сумдын ТТЗ	19	19	0	0	18	1	0
ОНӨҮГазар	4	4	0	0	1	3	0
Нийт	222	152	70	0	132	18	2

Аудитад хамрагдсан төсөв захирагчдын 132 тайланд “Зөрчилгүй”, 18 тайланд “Хязгаарлалттай”, 2 тайланд “Санал дүгнэлт өгөхөөс татгалзсан” дүгнэлтийг өгсөн байна.

3.11.1 Төсвийн ерөнхийлөн захирагчийн аудитын илрүүлэлт

Аймгийн ТЭЗ-ийн санхүүгийн тайлангийн аудитаар **10,853.1** сая төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс, аудитын явцад **9,095.7** сая төгрөгийн алдааг залруулж, санхүүгийн тайлангийн аудиттай холбоотой **1,739.2** сая төгрөгийн зөрчлийг арилгах, таслан зогсоох 4 албан шаардлага, нийцлийн аудиттай холбоотой **18.2** сая төгрөгийн зөрчилд 3 албан шаардлагын хүргүүлэн, 2 зөрчилтэй асуудалд зөвлөмж өгч ажиллалаа.

Аудитаар илэрсэн 1,757.4 сая төгрөгийн залруулагдаагүй алдаа зөрчлийн хувьд 19 сумын “Сум хөгжүүлэх сан”-гаас олгосон 5-аас дээш жилийн насжилттай зээлийн 1,691.9 сая төгрөгийн авлагын үлдэгдэлтэй байгаа зөрчлийг аймгийн хэмжээнд нэгдсэн арга хэмжээ авч, ажиллуулахаар ТЭЗ-ийн зөрчилд оруулан тооцсон бөгөөд уг зөрчил нь сумын Засаг дарга нарын нэгтгэсэн тайлангийн аудитаар илэрч холбогдох шийдвэрийг хүргүүлсэн тул материаллаг бус гэж үнэлсэн болно. Харин 65.5 сая төгрөгийн зөрчлийг материаллаг гэж үнэлсэн бөгөөд тогтоосон материаллаг байдлын түвшин 986.3 сая төгрөгтэй харьцуулахад бага байх тул “Зөрчилгүй” санал дүгнэлтийг хүргүүллээ.

Залруулга

Аймгийн ТЭЗ-ийн тайланд 9,095.7 сая төгрөгийн дараах залруулгуудыг хийлээ.Үүнд:

- Нэгдсэн тайлангийн өмчийн өөрчлөлтийн тайланд ГХБХБГ-ын 408.3 сая төгрөгийн засгийн газрын оруулсан капиталыг ТӨҮГ-ийн өмчөөр тайлагнасныг аудитын явцад залрууллаа.
- Нэгдсэн тайлангаар Ундарга ОНӨҮААТҮГ-аас хасагдаж, ОНӨГ-т бүртгэгдэх ёстой 8,687.4 сая төгрөгийн Азийн хөгжлийн банкны дамжуулан зээлийн өрийг бүртгээгүй байсныг урт хугацаат зээлийн өглөг дансанд бүртгүүлэн аудитын явцад залрууллаа.

Албан шаардлага

1. Аудитаар 19 сумын сум хөгжүүлэх сангийн зээлийн авлагын үлдэгдлийг насжилтаар нь судлан авч үзэхэд 5-с дээш жил насжилттай буюу 2011-2016 онуудад үүссэн 1,691.9 сая төгрөгийн авлагын үлдэгдэлтэй байгаа бөгөөд насжилт нэмэгдэхийн хэрээр авлага найдваргүй болох, сангийн хөрөнгийн эх үүсвэр дутагдах эрсдэлийг бий болгосон байна. Энэ нь Засгийн газрын 2016 оны 153 дугаар тогтоолоор

баталсан “Сум хөгжүүлэх сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, хяналт тавих журам”-ын /тухайн үед хүчин төгөлдөр байсан/ 4.7-д “Иргэн, хуулийн этгээд авсан зээл, зээлийн хүүг гэрээнд заасан хугацаанд сангийн дансанд буцаан төлнө” гэж заасныг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Хугацаатай хэтэрсэн авлагыг барагдуулах тодорхой арга хэмжээг авч, сумдын удирдлагуудад үүрэг чиглэл өгч, биелэлтийг тооцон ажиллах албан шаардлагыг хүргүүлээ.

2. "Хөдөөгийн ядуурлыг бууруулах төсөл"-ийн нэгжээс иргэдэд олгосон 5.1 сая төгрөгийн өр төлбөрийн үлдэгдлийг барагдуулах арга хэмжээг авч ажиллаагүй байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6.4.8-д "Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх" гэсэн заалтыг зөрчсөн.

Шийдвэрлэсэн нь: Өр төлбөрийн үлдэгдлийг барагдуулж, зөрчлийг арилгуулах албан шаардлагыг хүргүүлээ.

3. Орон нутгийн өмчит ААН-ийн санхүүгийн тайлангийн аудитаар 4 хуулийн этгээд хамрагдаж, “Ар-Ус Ундарга”, “Архангайд үйлдвэрлэв” болон Цөм сүрэг үржлийн төв ОНӨААТҮГ -уудад “Хязгаарлалттай” санал дүгнэлт, харин “Чулуут ахуйн үйлчилгээний төв” ОНӨААТҮГ-т “Зөрчилгүй” дүгнэлтийг өгсөн ба аудитаар нийт 369.2 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс аудитын явцад 98.6 сая төгрөгийн алдааг залруулсан бөгөөд илэрсэн алдаа зөрчил болон санхүүгийн үйл ажиллагааны үзүүлэлт, ашиг алдагдлын талаар авч үзвэл:

- **Ар Ус ундарга ОНӨААТҮГ** нь 101.8 сая төгрөгийн авлага үүсгэсэн, 116.4 сая төгрөгийн өр төлбөрийг тооцоо нийлж баталгаажуулаагүй, эрх бүхий байгууллагын шийдвэргүйгээр 2.7 сая төгрөгийн захирлын сургалтын төлбөрийг байгууллагаас төлсөн, 80.4 сая төгрөгийн хөрөнгө бэлтгэхдээ ОНӨГ-аас зөвшөөрөл аваагүй, тендер худалдан авах ажиллагааг зохион байгуулаагүй, 46.6 сая төгрөгийн баяр ёслол, шагнал урамшуулалд зарцуулан хөрөнгийг арвилан хэмнэлтгүй, үр ашиггүй зарцуулсан, 70.0 сая төгрөгийн алдагдалтай ажилласан байна.
- **Архангайд үйлдвэрлэв ОНӨААТҮГ** нь 2021 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг нарийн тооцоо судалгаагүй, алдагдалтай баталсан, түрээсийн төлбөрийн дүнд НӨАТ-ыг оруулан тооцолгүйгээр орлогын дансанд 7.2 сая төгрөгийн бууруулах бичилт хийсэн, 10.1 сая төгрөгийн өр, 6.9 сая төгрөгийн авлага үүсгэж, 30.9 сая төгрөгийн алдагдалтай ажилласан.
- **Цөм сүрэг үржлийн төв ОНӨААТҮГ** нь 9.5 сая төгрөгийн цалин олгосон анхан шатны баримтын бүрдэлгүй, цалингийн тооцооны дансыг сар бүр хөтлөөгүй жилийн эцэст нэг удаа бүртгэсэн, 1.9 сая төгрөгийн бараа материалын гүйлгээг татварын цахим системд бүртгүүлээгүй, НӨАТ-ын тайланд 2.2 сая төгрөгийн борлуулалтыг бодитоор илэрхийлээгүй, НӨАТ шингэсэн борлуулалт хийгээгүй, орон тооны нягтлан бодогчгүй байна.
- **Чулуут ахуйн үйлчилгээний төв ОНӨААТҮГ** нь 2.9 сая төгрөгийн авлага, 10.4 сая төгрөгийн өр төлбөр үүсгэж, 23.6 сая төгрөгийн алдагдалтай ажилласан байна.

Шийдвэрлэсэн нь: Аудитаар илэрсэн алдаа зөрчлийг таслан зогсоох, аймгийн засаг дарга болон ОНӨГ-ын зүгээс ОНӨААТҮГ-уудыг үр ашигтай, үр дүнтэй ажиллуулах талаар холбогдох арга хэмжээг авч ажиллах албан шаардлагыг хүргүүлэх

4. Эрдэнэмандал суманд сумын ИТХ-ын 2021 оны 5 дугаар тогтоолоор “Эрдэнэмандал Хөгжлийн дэд бүтэц” ОНӨААТҮГ, 6 дугаар тогтоолоор “Шилмэл сүргийн үржил” ОНӨААТҮГ-ыг тус тус шинээр байгуулсан байна. Тайлант хугацаанд “Эрдэнэмандал Хөгжлийн дэд бүтэц” ОНӨААТҮГ нь сумын 5 төсөвт байгууллагуудаас халаалтын төлбөрт 38.9 сая төгрөгийн, Шилмэл сүргийн үржил ОНӨААТҮГ нь 3.4 сая төгрөгийн орлогыг тус тус төвлөрүүлж үйл ажиллагаа явуулсан боловч жилийн санхүүгийн тайлангаа Төрийн аудитын газраар баталгаажуулж дүгнэлт гаргуулаагүй, санхүүгийн тайлангийн аудитад хамрагдаагүй. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Төсвийн тухай хуулийн 8.9.8-д “Төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээд жилийн эцсийн санхүүгийн тайлангаа дараа жилийн 02 дугаар сарын 15-ны дотор төрийн аудитын байгууллагад хүргүүлж, аудит хийсэн тайланг 3 дугаар сарын 15-ны дотор харьяалагдах төсвийн ерөнхийлөн захирагч болон санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлэх” гэсэн заалттай нийцэхгүй байна. Эдгээр ОНӨААТҮГ-ын талаар аймгийн ОНӨГ-аас тодруулахад 2022 оны 01 дүгээр сарын 18-ны өдрийн 14 тоот албан бичгээр ирүүлсэн тайлбарт “ОНӨГ-т албан ёсоор баримт материал ирүүлж мэдэгдээгүй, аймгийн ИТХ-аас суманд өмч шилжүүлсэн шийдвэр гараагүй тул сумын ОНӨААТҮГ байгуулах боломжгүй” гэсэн байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчлийг таслан зогсоож Төсвийн тухай хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллах албан шаардлагыг хүргүүлээ.

3.11.2 Аймгийн ТЕЗ-ийн харьяа байгууллагуудад хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүнгийн талаар

ОНТЕЗ-ийн харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд хийсэн аудитаар нийт **15,843.6** сая төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс аудитын явцад **6,905.9** сая төгрөгийн алдааг залруулж, **72.7** сая төгрөгийн зөрчилд 34 төлбөрийн акт тогтоож, **7,078.9** сая төгрөгийн зөрчилд зөрчлийг арилгах, таслан зогсоох 277 албан шаардлага, 77.5 сая төгрөгийн зөрчил гаргасан 9 албан тушаалтанд хариуцлага тооцуулах санал хүргүүлэн, **1,708.6** сая төгрөгийн зөрчилд 135 заалт бүхий зөвлөмж өгч ажилласан байна.

Аудитаар илрүүлсэн алдаа, зөрчлийн 56.4 хувь залруулагдаагүй алдаа зөрчил, 43.6 хувь нь залруулагдсан алдаа байна.

Аудитаар залруулагдсан 6,905.9 сая давхардсан тоогоор 58 байгууллагын нягтлан бодох бүртгэл тайлагналтай холбоотой залруулагдсан алдаа бөгөөд энэ нь нягтлан бодох бүртгэлийн ажилтны мэдлэг, ур чадвартай холбоотой байна

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар

Аудитад 19 сумын ТТЗ-ийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайлан хамрагдсанаас 18 сумын нэгтгэсэн тайланд “Зөрчилгүй”, Эрдэнэмандал сумын ТТЗ-ийн нэгтгэсэн тайланд “Хязгаарлалттай” санал дүгнэлтийг хүргүүлээ.

Аудитаар нийт 3,445.9 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс аудитын явцад 1,016.7 сая төгрөгийн алдааг залруулж, 3,396.6 сая төгрөгийн зөрчилд 52 албан шаардлага, зөрчил гаргасан 2 албан тушаалтанд хариуцлага тооцуулах санал хүргүүлэн, 49.3 сая төгрөгийн алдаа, зөрчилд 26 зөвлөмж өгч ажиллалаа.

Төсвийн шууд захирагчдын санхүүгийн тайлангийн аудитаар

Аудитад 158 төсвийн шууд захирагчийн санхүүгийн тайлан хамрагдсанаас 70 тайланг түүвэрт хамруулан шалгаж, 128 төсөв захирагчийн тайланд санал дүгнэлт хүргүүлээ.

Аудитаас санал дүгнэлт хүргүүлсэн 112 төсөв захирагчийн тайланд “Зөрчилгүй”, 14 төсөв захирагчийн тайланд “Хязгаарлалттай”, 2 төсөв захирагчийн тайланд “Санал дүгнэлт өгөхөөс татгалзсан” байна.

Хязгаарлалттай болон санал дүгнэлт өгөхөөс татгалзсан дараах байгууллагууд байна.

№	Байгууллагын нэр	Дүгнэлтийн төрөл
1	Хөгжимт драмын театр	Хязгаарлалттай
2	Байгаль орчин, аялал жуулчлалын газар	Хязгаарлалттай
3	Цахир сумын ЗДТГ	Хязгаарлалттай
4	Жаргалант сумын ЗДТГ	Хязгаарлалттай
6	Тариат сумын ЗДТГ	Хязгаарлалттай
7	Эрдэнэмандал сумын ИТХ	Хязгаарлалттай
8	Цэнхэр сумын ИТХ	Хязгаарлалттай
9	Цэнхэр сумын ЗДТГ	Хязгаарлалттай
10	Цэнхэр сумын ЭМТ	Хязгаарлалттай
11	Чулуут сумын ЭМТ	Хязгаарлалттай
12	Тариат сумын ЭМТ	Хязгаарлалттай
13	Цэцэрлэг сумын ЭМТ	Хязгаарлалттай
14	Өлзийт сумын соёлын төв	Хязгаарлалттай
15	Ирээдүй сургууль	Санал дүгнэлт өгөхөөс татгалзсан
16	Ирээдүй цэцэрлэг	Санал дүгнэлт өгөхөөс татгалзсан

ТШЗ-ийн санхүүгийн тайлангийн аудитаар нийт 11,011.8 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс аудитын явцад 5,790.6 сая төгрөгийн алдааг залруулан, 70.0 сая төгрөгийн зөрчилд 33 төлбөрийн акт, 3,420.8 сая төгрөгийн зөрчилд 214 албан шаардлага, 1,652.8 сая төгрөгийн алдаа, зөрчилд 103 зөвлөмж, 77.5 сая төгрөгийн зөрчил гаргасан 7 албан тушаалтанд хариуцлага тооцуулах санал хүргүүлээ.

Төрийн болон орон нутгийн өмчит аж ахуйн нэгжийн санхүүгийн тайлангийн аудитаар

Аудитад 4 ОНӨҮГ-ын санхүүгийн тайлан хамрагдаж, Ар-Ус Ундарга, Цөм сүрэг үржийн төв, Архангайд үйлдвэрлэв ОНӨААТҮГ-уудын санхүүгийн тайланд “Хязгаарлалттай” санал дүгнэлт, харин Чулуут ахуйн үйлчилгээний төв ОНӨААТҮГ-ын санхүүгийн тайланд “Зөрчилгүй” дүгнэлтийг хүргүүлээ.

Аудитаар нийт 369.2 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс аудитын явцад 98.6 сая төгрөгийн алдааг залруулан, 2.7 сая төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт тогтоож, 261.4 сая төгрөгийн зөрчилд 11 албан шаардлага, 6.5 сая төгрөгийн зөрчилд 6 зөвлөмж өгч ажиллалаа.

Тусгай санд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар

Аудитад 41 тусгай сангийн санхүүгийн тайлан хамрагдсанаас 40 тайланг түүвэрт хамруулан шалгаж, 1 тайланд санал дүгнэлт хүргүүлээ. Халамжийн сангийн санхүүгийн тайланд аудит хийж, зөрчилгүй санал дүгнэлт хүргүүлсэн бөгөөд аймгийн болон 19 сумын

ОНХС, СХС-ийн санхүүгийн тайланг түүвэрт хамруулан шалгаж, зөрчлийг сумын ТТЗ-ийн санхүүгийн тайлангийн аудитад хамаарууллаа.

3.12 ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ БУЮУ АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДАЛ

Дараагийн санхүүгийн тайлангийн аудитаар аймгийн нэгдсэн тайланд тусгагдсан авлага, өр төлбөрийг барагдуулах талаар авч хэрэгжүүлсэн арга хэмжээ болон ОНӨҮГ-уудын үйл ажиллагааны үр дүн, ашигт ажиллагаа, санхүүгийн тайлагналын талаар авч хэрэгжүүлсэн арга хэмжээний биелэлтийг шалгана.

4. АУДИТЫН ЗӨВЛӨМЖ

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав.

**АРХАНГАЙ АЙМГИЙН ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧ М.БАТЖАРГАЛ,
СТСХ-ИЙН ДАРГА Ж.МӨНХБАТ, ОНӨГ-ЫН Х.ГАНХУЯГ НАРТ**

4.1 ӨР ТӨЛБӨРИЙН ДАНСТАЙ ХОЛБООТОЙ АСУУДАЛ

Илрүүлэлт:

Аймгийн ТЕЗ-ийн нэгтгэсэн тайлангаар төсөвт байгууллагуудын богино хугацаат өр төлбөр 1,139.2 сая төгрөгөөр тайлагнагдсаны 66.1 хувь буюу 752.8 сая төгрөг нь нэгдсэн халаалтанд шилжсэнтэй холбоотой халаалтын өр байна. Үүнд:

- Тариат сумын Соёлын төвийн 15.1 сая төгрөгийн,
- Өлзийт сумын ЕБС-ийн 514.1 сая төгрөг, Соёлын төвийн 111.8 сая төгрөгийн,
- Эрдэнэбулган сумын 1-р сургуулийн өргөтгөл шинээр ашиглалтанд орсонтой холбоотой 111.8 сая төгрөгийн өр байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6.4.8-д "Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх" гэсэн заалтыг зөрчсөн бөгөөд "нийцсэн бөгөөд зохистой байх" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж:

- Төсвийн тухай хуулийн хэрэгжилтийг хангуулж, өр төлбөрийг барагдуулах талаар Аймгийн ТЕЗ-ийн зүгээс тодорхой арга хэмжээ авч ажиллах
- Цаашид шинээр өр төлбөр үүсгэхгүй байхад анхаарч, сумдын удирдлагуудад үүрэг чиглэл өгч ажиллах

4.2 НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛ ТАЙЛАГНАЛТАЙ ХОЛБООТОЙ АСУУДАЛ

Илрүүлэлт:

Аймгийн ТЕЗ-ийн харьяа байгууллагуудын санхүүгийн тайлангийн аудитаар нийт 15,843.6 сая төгрөгийн зөрчил илэрсэн бөгөөд үүний 6,905.9 сая төгрөг буюу 43.6 хувь нь давхардсан тоогоор 58 байгууллагын нягтлан бодох бүртгэл тайлагналтай холбоотой залруулагдсан алдаа бөгөөд энэ нь нягтлан бодох бүртгэлийн ажилтны мэдлэг, ур чадвартай холбоотой байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Сангийн сайдын 388, 361 дугаар тушаалыг зөрчсөн байна.

Өгсөн зөвлөмж:

- Нягтлан бодогчдын мэргэжлийн ур чадварыг дээшлүүлэх, сургах, чадавхижуулах, мэргэшүүлэх талаар аймгийн засаг дарга, СТСХ-ийн зүгээс тодорхой арга хэмжээ авч, үр дүнг тооцон ажиллах

Зөвлөмжийн биелэлт болон хийж хэрэгжүүлсэн ажлын тайланг 2022 оны 12 дугаар сарын 01-ний дотор Архангай аймаг дахь Төрийн аудитын газарт албан бичгээр ирүүлнэ үү.

5. АУДИТААР ИЛЭРСЭН АЛДАА, ЗӨРЧЛИЙН НЭГТГЭЛ

/сая төгрөгөөр/

д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Санхүүгийн тайлангийн аудитын асуудал											
1	Аймгийн ТЕЗ	8	10,834.9	2	9,095.7	0	0	4	1,739.2	2	0
Дүн		8	10,834.9	2	9,095.7	0	0	4	1,739.2	2	0
Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал											
1	Аймгийн ТЕЗ	3	18.2	0	0	0	0	3	18.2	0	0
Дүн		3	18.2	0	0	0	0	3	18.2	0	0
Нийт дүн		11	10,853.1	2	9,095.7	0	0	7	1,757.4	2	0

6.Аймгийн ТЕЗ-аас ирүүлсэн асуудлын бүртгэлийн хариу



МОНГОЛ УЛС
АРХАНГАЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА


65139 Архангай аймаг, Эрдэнэбулган сум, 2 дугаар баг,
Утас/Факс: (976) 7033 3208,
И-мэйл: arkhangai.gov@gmail.com,
Вэбсайт: www.arkhangai.gov.mn

2022.04.21 № 01/677

танай _____-ны № _____-т

「 АРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН
АУДИТЫН ГАЗАРТ

Танай байгууллагаас ирүүлсэн санхүүгийн
нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангийн
асуудлын бүртгэлтэй танилцлаа.
Нэмэлт тайлбар санал байхгүй болно.



М.БАТЖАРГАЛ

6513940297

7. Аудитын тайлан баталгаажуулсан тушаал



АРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН
ТУШААЛ

2022 оны 04 сарын 20 өдөр

Дугаар 1/07

Цэцэрлэг

Тайлан баталгаажуулах тухай

Монгол Улсын Ерөнхий аудиторов 2018 оны А/207 тушаалын 5 дугаар хавсралтын 2.4, 2020 оны а/95 дугаар тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагын акт тогтоох, албан шаардлага өгөхөд баримтлах журам”-ын 7.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Архангай аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2021 оны төсвийн гүйцэтгэл, санхүүгийн нэгтгэсэн тайлан”-д хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг тус тус баталгаажуулсугай.

2. Аудитаас өгөгдсөн албан шаардлагыг хавсралтаар баталсугай.

3. “Архангай аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2021 оны төсвийн гүйцэтгэл, санхүүгийн нэгтгэсэн тайлан”-д хийсэн аудитын тайлангуудыг Үндэсний аудитын газар, аймгийн Засаг дарга болон ИТХ-ын даргад тус тус хүргүүлсүгэй.

4. Аудитаар өгөгдсөн зөвлөмж албан шаардлагын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг ахлах аудитор Н.Алтантуяад үүрэг болгосугай.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Т.БАЙГАЛМАА

00301060

Тэргүүлэх аудиторын 2022 оны
04 сарын 20 өдрийн /107/ дугаар
тушаалын хавсралт

**АРХАНГАЙ АЙМГИЙН ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧИЙН
2021 ОНЫ ЖИЛИЙН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ, САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАНД
ХИЙСЭН АУДИТААР ХҮРГҮҮЛСЭН АЛБАН ШААРДЛАГА**

№	Албан шаардлага хүргүүлсэн байгууллагын нэр	Албан шаардлагын дугаар	Мөнгөн дүн /сая төгрөг/	Хариуцсан аудитор
1	Аймгийн ТЕЗ	311/A0340210	4,394.6	П.Энхжаргал
2	Аймгийн ТЕЗ	312/A0340210	5.1	Н.Алтантуяа
3	Аймгийн ТЕЗ	313/A0340210	1,691.9	Н.Алтантуяа
4	Аймгийн ТЕЗ	314/A0340210		Н.Алтантуяа
5	Аймгийн ТЕЗ	315/A0340210		Н.Алтантуяа
6	Аймгийн ТЕЗ	316/A0340210	42.3	Н.Алтантуяа
7	Аймгийн ТЕЗ	317/A0340210	18.2	Н.Алтантуяа
8	Аймгийн ТЕЗ	318/A0340210		Н.Алтантуяа
Нийт дүн			6,152.1	

8. Хүргүүлсэн албан шаардлага, зөвлөмж



АРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 04 сарын 20 өдөр

Дугаар 312/А0340210

Цэцэрлэг

Зөрчил арилгуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1-д заасан бүрэн эрхийн хүрээнд Архангай аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитаар "Хөдөөгийн ядуурлыг бууруулах төсөл"-ийн нэгжээс иргэдэд олгосон 5.1 сая төгрөгийн өр төлбөрийн үлдэгдлийг барагдуулах арга хэмжээг авч ажиллаагүй зөрчил илэрлээ.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6.4.8-д "Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх" гэсэн заалтыг зөрчсөн байна.

Иймд Төрийн Аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын ерөнхий аудиторовын 2020 оны оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1-д заасныг үндэслэн ШААРДАХ нь:

1. Төсвийн тухай хуулийг хэрэгжүүлж, өр төлбөрийн үлдэгдлийг барагдуулах арга хэмжээ авч ажиллан биелэлтийг 2022 оны 12 дугаар сарын 01-ний дотор Архангай аймаг дахь Төрийн аудитын газар¹-т ирүүлэх
2. Цаашид зөрчлийг таслан зогсоож давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг аймгийн Засаг дарга М.Батжаргал, Санхүү төрийн сангийн хэлтсийн дарга Ж.Мөнхбат нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР *Т.Байгалмаа* Т.БАЙГАЛМАА



¹ Монгол Улс, Архангай аймаг, Эрдэнэбулган сум, 3-р баг, аймгийн ЗДТГ-ын байр, Утас:70333019



АРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 04 сарын 20 өдөр

Дугаар 313/А0340210

Цэцэрлэг

Зөрчил арилгуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1-д заасан бүрэн эрхийн хүрээнд Архангай аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ.

Архангай аймгийн 19 сумын сум хөгжүүлэх сангийн зээлийн авлагын үлдэгдлийг насжилтаар нь судлан авч үзэхэд 5-с дээш жил насжилттай буюу 2011-2016 онуудад үүссэн 1,691.9 сая төгрөгийн авлагын үлдэгдэлтэй байгаа бөгөөд насжилт нэмэгдэхийн хэрээр авлага найдваргүй болох, сангийн хөрөнгийн эх үүсвэр дутагдах эрсдэлийг бий болгосон байна.

Энэ нь Засгийн газрын 2016 оны 153 дугаар тогтоолоор баталсан "Сум хөгжүүлэх сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, хяналт тавих журам"-ын /тухайн үед хүчин төгөлдөр байсан/ 4.7-д "Иргэн, хуулийн этгээд авсан зээл, зээлийн хүүг гэрээнд заасан хугацаанд сангийн дансанд буцаан төлнө" гэсэн заалтыг зөрчсөн байна.

Иймд Төрийн Аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын ерөнхий аудиторов 2020 оны оны А/95 тоот тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1-д заасныг үндэслэн ШААРДАХ нь:

1. Хугацаа хэтэрсэн болон чанаргүй зээлийн авлагыг барагдуулах арга хэмжээг авч ажиллан биелэлтийг 2022 оны 12 дугаар сарын 01-ний дотор Архангай аймаг дахь Төрийн аудитын газар¹-т ирүүлэх
2. Цаашид зөрчлийг таслан зогсоож, давтан гаргахгүй байх арга хэмжээг авч ажиллахыг аймгийн Засаг дарга М.Батжаргал, Санхүү төрийн сангийн хэлтсийн дарга, Ж.Мөнхбат, Ерөнхий нягтлан бодогч Ц.Батцэцэг нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Т.БАЙГАЛМАА

¹ Монгол Улс, Архангай аймаг, Эрдэнэбулган сум, 3-р баг, аймгийн ЭДТ-ын байр, Утас:70333019



АРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2021 оны 04 сарын 20 өдөр

Дугаар 314/А0340210

Цэцэрлэг

Зөрчил арилгуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1-д заасан бүрэн эрхийн хүрээнд Архангай аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитаар өмнөх оны зөвлөмжийг хэрэгжүүлээгүй дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Орон нутгийн өмчит ААН-ийн санхүүгийн тайлангийн аудитаар "Ар-Ус Ундарга", "Архангайд үйлдвэрлэв" болон Цөм сүрэг үржлийн төв ОНӨААТҮГ-уудад "Хязгаарлалттай" санал дүгнэлт, "Чулуут ахуйн үйлчилгээний төв" ОНӨААТҮГ-т "Зөрчилгүй" дүгнэлтийг өгсөн ба аудитаар нийт 369.2 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрсэн. Үүнээс аудитын явцад 98.6 сая төгрөгийн алдааг залруулсан бөгөөд холбогдох хууль, тогтоомжийн хэрэгжилт хангалтгүй, үр ашиггүй ажилласан байна. Тухайлбал:

- Ар Ус ундарга ОНӨААТҮГ нь 101.8 сая төгрөгийн авлага үүсгэсэн, 116.4 сая төгрөгийн өр төлбөрийг тооцоо нийлж баталгаажуулаагүй, эрх бүхий байгууллагын шийдвэргүйгээр 2.7 сая төгрөгийн захирлын сургалтын төлбөрийг байгууллагаас төлсөн, 80.4 сая төгрөгийн хөрөнгө бэлтгэхдээ ОНӨГ-аас зөвшөөрөл аваагүй, тендер худалдан авах ажиллагааг зохион байгуулаагүй, 46.6 сая төгрөгийн баяр ёслол, шагнал урамшуулалд зарцуулан хөрөнгийг арвилан хэмнэлтгүй, үр ашиггүй зарцуулсан, 70.0 сая төгрөгийн алдагдалтай ажилласан байна.
- Архангайд үйлдвэрлэв ОНӨААТҮГ нь 2021 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг нарийн тооцоо судалгаагүй, алдагдалтай баталсан, түрээсийн төлбөрийн дүнд НӨАТ-ыг оруулан тооцолгүйгээр орлогын дансанд 7.2 сая төгрөгийн бууруулах бичилт хийсэн, 10.1 сая төгрөгийн өр, 6.9 сая төгрөгийн авлага үүсгэж, 30.9 сая төгрөгийн алдагдалтай ажилласан.
- Цөм сүрэг үржлийн төв ОНӨААТҮГ нь 9.5 сая төгрөгийн цалин олгосон анхан шатны баримтын бүрдэлгүй, цалингийн тооцооны дансыг сар бүр хөтлөөгүй жилийн эцэст нэг удаа бүртгэсэн, 1.9 сая төгрөгийн бараа материалын гүйлгээг татварын цахим системд бүртгүүлээгүй, НӨАТ-ын тайланд 2.2 сая төгрөгийн борлуулалтыг бодитоор илэрхийлээгүй, НӨАТ шингэсэн борлуулалт хийгээгүй, орон тооны нягтлан бодоггүй байна.
- Чулуут ахуйн үйлчилгээний төв ОНӨААТҮГ нь 2.9 сая төгрөгийн авлага, 10.4 сая төгрөгийн өр төлбөр үүсгэж, 23.6 сая төгрөгийн алдагдалтай ажилласан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6.4.1-т "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 6.4.4-т Хуульд өөрөөр заагаагүй бол бараа нийлүүлэх, ажил гүйцэтгэх, үйлчилгээ үзүүлэх этгээдийг чөлөөт өрсөлдөөн, нээлттэй сонгон шалгаруулалтын аргаар сонгох", 6.4.8-д "Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", 25.10-д "Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд хандив, тусламж өгөхийг хориглоно", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14.4-т "Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлийг заавал бүртгэнэ", 20.2.6 "Эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах", Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.1, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1, 46 дугаар зүйлийн 46.1.4, 46.1.5, 48 дугаар зүйлийн 48.5, Татварын ерөнхий хуулийн 28.1-д "Татвар төлөгч холбогдох татварын хуулиар төлбөл зохих татварын ногдлоо өөрөө тодорхойлж, хуулиар тогтоосон хугацаанд төсөвт төлнө", Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 8.1-д "албан татварыг дор дурдсан журмаар ногдуулна", 8.1.1-д "бараа, ажил, үйлчилгээг ... борлуулсан бол тухай бүрд" гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

Иймд Төрийн Аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын ерөнхий аудиторов 2020 оны оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.10-д "аудитаар илэрсэн алдаа, зөрчил, түүнийг арилгахаар өгсөн зөвлөмжийг хугацаанд нь хэрэгжүүлээгүй бол" албан шаардлага өгөх гэсэн заалтуудыг үндэслэн ШААРДАХ нь:

1. Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн удирдлага зохион байгуулалтыг орон нутаг болон салбарын бодлого, зохицуулалтаар хангах, төр өөрийн оруулсан өмч, хөрөнгөөс өгөөж хүртэх, компанийн үр ашгийг нэмэгдүүлэх, төсвийн орлого бүрдүүлэх зэрэгт аймгийн Засаг дарга болон ОНӨГ-ын зүгээс холбогдох арга хэмжээг авч ажиллан биелэлтийг 2022 оны 12 дугаар сарын 01-ний дотор Архангай аймаг дахь Төрийн аудитын газар¹-т ирүүлэх
2. Цаашид зөрчлийг таслан зогсоож давтан гаргахгүй байх арга хэмжээг авч ажиллахыг аймгийн Засаг дарга М.Батжаргал, Орон нутгийн өмчийн газрын Х.Ганхуяг, Санхүү төрийн сангийн хэлтсийн дарга Ж.Мөнхбат нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  Т.БАЙГАЛМАА



¹ Монгол Улс, Архангай аймаг, Эрдэнэбулган сум, 3-р баг, аймгийн ЗДТГ-ын байр, Утас:70333019



АРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 04 сарын 20 өдөр

Дугаар 315/АДЗЧОЗ10

Цэцэрлэг

Зөрчил арилгуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1-д заасан бүрэн эрхийн хүрээнд Архангай аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитаар шилэн дансны цахим хуудсанд оруулбал зохих 158 мэдээлэл байршуулахаас 103 мэдээллийг хугацаанд нь 44 мэдээллийг хугацаа хоцроож, 11 мэдээллийг огт байршуулаагүй зөрчил илэрлээ.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3-т "тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх", 6 дугаар зүйлийн 6.1-6.10-д заасан "төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд, байгууллага, албан тушаалтан дараах мэдээллийг тогтмол мэдээлнэ ..." гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Иймд Төрийн Аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын ерөнхий аудиторовын 2020 оны оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1, 2021 оны А/108 дугаар тушаалын хавсралтаар баталсан "Төрийн аудитын байгууллагаас шилэн дансны 2021-2022 оны үйл ажиллагаанд хөндлөнгийн хяналтыг хэрэгжүүлэх ерөнхий чиглэл"-ийн 3.1.1-д заасныг тус тус үндэслэн ШААРДАХ нь:

1. Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлж, таслан зогсоох, зөрчлийг арилган биелэлтийг 2022 оны 12 дугаар сарын 01-ний дотор Архангай аймаг дахь Төрийн аудитын газар¹-т ирүүлэх
2. Цаашид алдаа зөрчлийг давтан гаргахгүй байх арга хэмжээг авч ажиллахыг аймгийн Засаг дарга М.Батжаргал, Санхүү төрийн сангийн хэлтсийн дарга Ж.Мөнхбат, Орон нутгийн өмчийн газрын дарга Х.Ганхуяг, Хөрөнгө оруулалт хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн дарга Ц.Амаржаргал нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  БАЙГАЛМАА

6517143980

¹ Монгол Улс, Архангай аймаг, Эрдэнэбулган сум, Зар Батсайханы 3ДТГ-ын байр, Утас:70333019



АРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 04 сарын 20 өдөр

Дугаар 316/АДЗНД210

Цэцэрлэг

Зөрчил арилгуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1-д заасан бүрэн эрхийн хүрээнд Архангай аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайланд аудитаар Эрдэнэмандал суманд сумын ИТХ-ын 2021 оны 5 дугаар тогтоолоор байгуулсан "Эрдэнэмандал Хөгжлийн дэд бүтэц" ОНӨААТҮГ, 6 дугаар тогтоолоор байгуулсан "Шилмэл сүргийн үржил" ОНӨААТҮГ-ыг тайлант хугацаанд "Эрдэнэмандал Хөгжлийн дэд бүтэц" ОНӨААТҮГ нь сумын 5 төсөвт байгууллагуудаас халаалтын төлбөрт 38.9 сая төгрөгийн, Шилмэл сүргийн үржил ОНӨААТҮГ нь 3.4 сая төгрөгийн орлогыг тус тус төвлөрүүлж үйл ажиллагаа явуулсан боловч жилийн санхүүгийн тайлангаа Төрийн аудитын газарт баталгаажуулж дүгнэлт гаргуулах санхүүгийн тайлангийн аудитад хамрагдаагүй зөрчил илэрлээ.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Төсвийн тухай хуулийн 8.9.8-д "Төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээд жилийн эцсийн санхүүгийн тайлангаа дараа жилийн 02 дугаар сарын 15-ны дотор төрийн аудитын байгууллагад хүргүүлж, аудит хийсэн тайланг 3 дугаар сарын 15-ны дотор харьяалагдах төсвийн ерөнхийлөн захирагч болон санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлэх" гэсэн заалттай нийцэхгүй байна.

Иймд Төрийн Аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 "Шалгадагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын ерөнхий аудиторын 2020 оны оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.11-д заасныг үндэслэн ШААРДАХ нь:

1. Төсвийн тухай хуулийг хэрэгжүүлж, ОНӨАТҮГ-уудыг хуулийн хугацаанд аудитад бүрэн хамруулах арга хэмжээ авч ажиллан биелэлтийг 2022 оны 12 дугаар сарын 01-ний дотор Архангай аймаг дахь Төрийн аудитын газар¹-т ирүүлэх
2. Цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх арга хэмжээг авч ажиллахыг аймгийн Засаг дарга М.Батжаргал, Санхүү төрийн сангийн хэлтсийн дарга Ж.Мөнхбат, Орон нутгийн өмчийн газрын дарга Х.Ганхуяг нарт даалгав

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Т.БАЙГАЛМАА

¹ Монгол Улс, Архангай аймаг, Эрдэнэбулган сум, 3-р баг, аймгийн ЗДТГ-ын байр, Утас:70333019



АРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 04 сарын 20 өдөр

Дугаар 317/А0340210

Цэцэрлэг

Зөрчил арилгуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1-д заасан бүрэн эрхийн хүрээнд Архангай аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайланд аудит хийлээ. Аудитаар аймгийн Засаг даргын 2019 оны 10 дугаар 04-ний өдрийн "Аймгийн ЗДТГ-ын бүтэц, орон тоог шинэчлэн батлах тухай" А/517 тоот захирамж, аймгийн ЗДТГ-ын даргын 2020 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн "Аймгийн ЗДТГ-ын нийтлэг үйлчилгээний газрын бүтэц, орон тоог шинэчлэн батлах тухай" А/80 дугаар тушаалаар батлагдсан орон тооноос 8 орон тоогоор илүү ажиллаж, цалинд 18.2 сая төгрөгийг олгосон зөрчил илэрлээ.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-т "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж зарцуулах", 16 дугаар зүйлийн 16.5.3 "Батлагдсан цалингийн сан, орон тооны хязгаарт багтан төсвийн байгууллагын ажиллагчдын орон тоо, цалин хөлсийг тогтоох", Монгол Улсын ЗГ-ын 2016 оны "Аймгийн засаг даргын тамгын газрын бүтцийг шинэчлэн тогтоох тухай" 9 дүгээр тогтоолын "Орон нутгийн онцлог, нутаг дэвсгэрийн хэмжээ, хүн амын тоо, эдийн засаг, үйлдвэрлэлийн цар хүрээнээс хамааруулан Архангай, ... аймгийн ЗДТГ-ыг 41 хүртэл орон тоотой байхаар тогтоосугай", Монгол Улсын ЗГ-ын 2021 оны "Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай" 43 дугаар тогтоолын 1.2-т "Шинээр ажлын чиг үүрэг, албан тушаал бий болгохгүй, орон тоог нэмэгдүүлэхгүй байх, ... цалингийн зардлыг хэмнэх" гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Иймд Төрийн Аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын ерөнхий аудиторовын 2020 оны оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1-д заасныг үндэслэн ШААРДАХ нь:

1. Төсвийн тухай хууль, "Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай" Монгол Улсын ЗГ-ын 2021 оны 43, 388 дугаар тогтоолын хэрэгжилтийг

ханган ажиллан биелэлтийг 2022 оны 12 дугаар сарын 01-ний дотор Архангай аймаг дахь Төрийн аудитын газар¹-т ирүүлэх

- Цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлэн ажиллахыг аймгийн Засаг дарга М.Батжаргал, Санхүү төрийн сангийн хэлтсийн дарга Ж.Мөнхбат, ерөнхий нягтлан бодогч Ц.Батцэцэг нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Т.БАЙГАЛМАА

¹ Монгол Улс, Архангай аймаг, Эрдэнэбулган сум, 3-р баг, аймгийн ЗДТГ-ын байр, Утас:70333019



АРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 04 сарын 20 өдөр

Дугаар 318/А0340210

Цэцэрлэг

Зөрчил арилгуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1-д заасан бүрэн эрхийн хүрээнд Архангай аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайланд аудит хийлээ. "Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай" Монгол Улсын Засгийн газрын 43 дугаар тогтоолыг хэрэгжилтийг Аймгийн ТЕЗ-ийн харьяа байгууллагуудын санхүүгийн тайлангийн аудитаар шалгахад 810.1 сая төгрөгийн дараах зөрчил илэрлээ.

- Засгийн газрын 2021 оны "Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай" 43 дугаар тогтоолын 1.1-т "үндсэн үйл ажиллагаатай холбоотой, зайлшгүй шаардлагатайгаас бусад бүх төрлийн зардал, арга хэмжээг тэвчиж, зардал гаргахгүй байх, батлагдсан төсөвт зардлын дүнд 10-аас доошгүй хувийн хэмнэлт гаргахаар тооцож, урсгал болон хөрөнгийн зардлыг төлөвлөн хуваарилах", 1.8-т "Байгууллагын цахилгаан, дулааны эрчим хүч, цэвэр усны хэрэглээнд 20-иос доошгүй хувийн хэмнэлт гаргах", 1.9-т "бичиг хэрэг, албан хэрэг хөтлөлтийг байгууллагын дотоод сүлжээнд цахим хэлбэрт шилжүүлэх замаар бичиг хэрэг, цаас, хувилагч, хэвлэгчийн хормы зэрэг зардлыг бууруулах" гэсэн заалтуудтай нийцүүлж үзэхэд 54 байгууллага 667.9 сая төгрөгийн хэмнэлтийг бий болгож ажиллаагүй,
- Тогтоолын 1.2-т "Шинээр ажлын чиг үүрэг, албан тушаал бий болгохгүй, орон тоог нэмэгдүүлэхгүй байх, өндөр насны тэтгэвэр тогтоолгож чөлөөлөгдсөн ажилтан, албан тушаалтны орон тоог царцааж, нөхөн томилгоо хийхгүйгээр цалингийн зардлыг хэмнэх" гэсэн заалттай нийцүүлж үзэхэд 5 байгууллагатай холбоотой 47.8 сая төгрөгийн,
- Тогтоолын 1.4-т "Энэ тогтоол батлагдахаас өмнө төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу зарлагдсанаас бусад автомашин, албан конторын тавилга, ... тоног төхөөрөмж, хэрэглэлийн худалдан авалтыг зохион байгуулахгүй байх" гэсэн заалттай нийцүүлж үзэхэд 21 байгууллагатай холбоотой 68.8 сая төгрөгийн,
- Тогтоолын 1.5-т "Салбарын хэмжээнд хийх сургалт, семинар, хурал, зөвлөгөөн болон газар дээрх хяналт-шалгалт зэргийг цахим хэлбэрээр зохион байгуулж, сургалт, семинар, хурал, зөвлөгөөн зэрэг арга хэмжээний болон дотоод албан томилолтын зардлыг хэмнэх;" гэсэн заалттай нийцүүлж үзэхэд сургалт семинар зохион байгуулж 25.6 сая төгрөгийн зардал гаргасан 2 байгууллагатай холбоотой зөрчил тус тус илэрсэн байна. Иймд 43 дугаар тогтоолыг хэрэгжүүлэн

төсөвт зардлыг хэмнэж ажиллах албан шаардлагыг төсөвт байгууллагуудад хүргүүлээд байна.


Энэ нь Монгол Улсын ЗГ-ын 2021 оны "Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай" 43 дугаар тогтоолын 1.1, 1.2, 1.4, 1.5, 1.8, 1.9 дэх заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Иймд Төрийн Аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын ерөнхий аудиторовын 2020 оны оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.11-д "Хууль тогтоомж, гэрээ хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож давтан гаргахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал"-д албан шаардлага өгнө гэсэн заалтуудыг үндэслэн ШААРДАХ нь:

1. 2022 оны санхүүгийн үйл ажиллагаанд Монгол улсын Засгийн газрын 388 дугаар тогтоолуудыг орон нутагт хэрэгжүүлэх нэгдсэн арга хэмжээ авч ажиллан биелэлтийг 2022 оны 12 дугаар сарын 01-ний дотор Архангай аймаг дахь Төрийн аудитын газар¹-т ирүүлэх
2. Цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх арга хэмжээг авч ажиллахыг аймгийн Засаг дарга М.Батжаргал, Санхүү төрийн сангийн хэлтсийн дарга Ж.Мөнхбат, ерөнхий нягтлан бодогч Ц.Батцэцэг нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Т.БАЙГАЛМАА

¹ Монгол Улс, Архангай аймаг, Эрдэнэбулган сум, 3-р баг, аймгийн ЗДТГ-ын байр, Утас:70333019



АРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

65130 Цэцэрлэг, Архангай аймаг

Утас/Факс: 976-70333141

И-мэйл: arkhangai@audit.gov.mn

2022.04.20 № 86
танай _____-ны № _____-т

АРХАНГАЙ АЙМГИЙН ЗАСАГ
ДАРГА М.БАТЖАРГАЛ ТАНАА

Зөвлөмж хүргүүлэх тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1-д заасан бүрэн эрхийн хүрээнд Архангай аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайланд аудит хийлээ. Аудитаар аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн харьяа байгууллагуудын санхүүгийн тайлангийн аудитаар нийт 15,843.6 сая төгрөгийн зөрчил илэрсэн бөгөөд үүний 43.6 хувь буюу 6,905.9 сая төгрөг байгууллагын нягтлан бодох бүртгэл тайлагналтай холбоотой залруулагдсан алдаа байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2-д "Төрийн аудитын байгууллага аудитын дүгнэлтэд тулгуурлан төрийн санхүү, төсөв, нийтийн өмчтэй холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний акт, бусад эрх зүйн актын хүрээнд ... төрийн санхүүгийн удирдлагыг сайжруулах зорилгоор шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтанд зөвлөмж өгнө" гэж заасны дагуу дараах зөвлөмжийг хүргүүлж байна.

1. Харьяа төсвийн байгууллагын нягтлан бодогчдын мэргэжлийн ур чадварыг дээшлүүлэх, сургах, чадавхижуулах, мэргэшүүлэх талаар тодорхой арга хэмжээ авч, үр дүнг тооцон ажиллах

Зөвлөмжийн биелэлтийг 2022 оны 12 дугаар сарын 01-ний дотор Архангай аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлнэ үү.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Т.БАЙГАЛМАА



АРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

65130 Цэцэрлэг, Архангай аймаг
Утас/Факс: 976-70333141
И-мэйл: arkhangai@audit.gov.mn

2022.04.20 № 87

танай _____ -ны № _____ -т

Зөвлөмж хүргүүлэх тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1-д заасан бүрэн эрхийн хүрээнд Архангай аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайланд аудит хийлээ. Аудитаар аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн нэгтгэсэн тайлангаар төсөвт байгууллагуудын богино хугацаат өр төлбөр 1,139.2 сая төгрөгийн өртэй байна. Үүнд:

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2-д "Төрийн аудитын байгууллага аудитын дүгнэлтэд тулгуурлан төрийн санхүү, төсөв, нийтийн өмчтэй холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний акт, бусад эрх зүйн актын хүрээнд ... төрийн санхүүгийн удирдлагыг сайжруулах зорилгоор шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтанд зөвлөмж өгнө" гэж заасны дагуу дараах зөвлөмжийг хүргүүлж байна.

1. Төсвийн тухай хуулийн хэрэгжилтийг хангуулж, өр төлбөрийг барагдуулах талаар Аймгийн ТЭЗ-ийн зүгээс тодорхой арга хэмжээ авч ажиллах

Зөвлөмжийн биелэлтийг 2022 оны 12 дугаар сарын 01-ний дотор Архангай аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлнэ үү.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Т.БАЙГАЛМАА